

**Хадгаламжийн Даатгалын Корпораци**

**Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын  
дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайлангууд болон  
хараат бус аудиторын тайлан**

**2018 оны 12 дугаар сарын 31**

## АГУУЛГА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

Санхүүгийн байдлын тайлан .....	5
Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
Мөнгөн гүйлгээний тайлан.....	8

#### Санхүүгийн тайлангуудын тодруулгууд

1. Ерөнхий мэдээлэл .....	9
2. Үйл ажиллагааны орчин .....	10
3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого .....	11
4. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон хэмжилтийн суурь.....	18
5. Шинэ ба өөрчлөгдсөн стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт .....	21
6. Нягтлан бодох бүртгэлийн шинэ мэдэгдлүүд .....	23
7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	24
8. Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт .....	25
9. Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага .....	25
10. Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт .....	28
11. Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан .....	28
12. Монголбанкнаас авсан зээл.....	29
13. Хүүгийн орлого .....	30
14. Хүүгийн зардал.....	31
15. Даатгалын хураамжийн орлого.....	31
16. Ерөнхий болон үйл ажиллагааны зардал.....	31
17. Оруулсан хөрөнгө .....	31
18. Санхүүгийн эрсдэлийн удирдлага .....	32
19. Санхүүгийн хэрэглүүрүүдийн хэмжилтийн ангиллаарх тодруулга .....	36
20. Болзошгүй өр төлбөр ба үүрэг .....	37
21. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн тодруулга .....	38
22. Холбоотой талуудын ажил гүйлгээ.....	40
23. Тайлант хугацааны дараах үйл явдлууд.....	41
24. 2018 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлогууд.....	41

## Хараат бус аудиторын тайлан

Хадгаламжийн Даатгалын Корпорацийн Үндэсний Хороонд

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Хадгаламжийн Даатгалын Корпораци (“ХДК” гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

### Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий ХДК-ийн санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан,
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулга

### Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

### Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу ХДК-аас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

### *Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)*

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага ХДК-ийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон ХДК-ийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

ХДК-ийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

### *Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага*

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- ХДК-ийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- ХДК нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын



*Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага  
(үргэлжлэл)*

нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан ХДК-ийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид удирдлагад аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Гарын үсэг зурсан:



Давзагийн Баярмаа  
Гүйцэтгэх захирал  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Тапия  
Захирал  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Улаанбаатар, Монгол Улс

2019 оны 4 сарын 30-ны өдөр

**Хадгаламжийн Даатгалын Корпораци  
Санхүүгийн байдлын тайлан**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2018 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>			
	7	397,409,518	222,889,158
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө			
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	8	4,185,546	109,270,112
Эрх хүлээн авагч, Засгийн газраас авах авлага	9	73,796,145	84,599,061
Даатгалын хураамжийн авлага		1,920,635	1,940,923
Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	10	85,000,000	-
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт	10	-	85,000,000
Үндсэн хөрөнгө		757,032	777,304
Биет бус хөрөнгө		546,882	628,094
Бусад санхүүгийн бус хөрөнгө		124,740	73,101
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>563,740,498</b>	<b>505,177,753</b>
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			
Оруулсан хөрөнгө	17	100,000,000	100,000,000
Хуримтлагдсан ашиг		218,742,131	214,358,693
<b>НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>318,742,131</b>	<b>314,358,693</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Худалдааны болон бусад өр төлбөр		10,081	10,583
Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан	11	51,243,353	-
Монголбанкнаас авсан зээл	12	193,744,933	190,808,477
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>244,998,367</b>	<b>190,819,060</b>
<b>НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>563,740,498</b>	<b>505,177,753</b>

2019 оны 4 дүгээр сарын 30-ний өдөр Үндэсний Хороог төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрөн гарын үсэг зурав.



Г.Бат-Эрдэнэ  
Нягтлан бодогч

**Хадгаламжийн Даатгалын Корпораци**  
**Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Тодруулга</b>	<b>2018</b>	<b>2017</b>
Хүүгийн орлого	13	29,591,636	38,675,322
Бусад адитлгах орлого		224,349	140,452
Хүүгийн зардал	14	(592,898)	(555,746)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>29,223,087</b>	<b>38,260,028</b>
Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сангийн зардал	11	(51,243,353)	-
<b>Нөөц сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого</b>		<b>(22,020,266)</b>	<b>38,260,028</b>
Даатгалын хураамжийн орлого	15	42,945,923	36,085,731
Ерөнхий болон үйл ажиллагааны зардал	16	(2,852,245)	(2,435,442)
Авлагын алдагдлын сангийн зардал	9	(1,303,794)	(13,203,620)
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>16,769,618</b>	<b>58,706,697</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>16,769,618</b>	<b>58,706,697</b>

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-43 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**Хадгаламжийн Даатгалын Корпораци**  
**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Оруулсан хөрөнгө</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>Нийт эзэмшигчдийн өмч</b>
<b>2017 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000</b>	<b>155,651,996</b>	<b>255,651,996</b>
Тайлант жилийн ашиг	-	58,706,697	58,706,697
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	58,706,697	58,706,697
<b>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000</b>	<b>214,358,693</b>	<b>314,358,693</b>
СТОУС 9 –ийн хэрэгжилт: -хүлээгдэж буй алдагдлын дахин хэмжилт		(12,386,180)	(12,386,180)
<b>2018 оны 1 сарын 1-ний дахин тайлагнасан үлдэгдэл</b>	<b>100,000,000</b>	<b>201,972,513</b>	<b>301,972,513</b>
Тайлант жилийн ашиг	-	16,769,618	16,769,618
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	16,769,618	16,769,618
<b>2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000</b>	<b>218,742,131</b>	<b>318,742,131</b>

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-43 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**Хадгаламжийн Даатгалын Корпораци**  
**Мөнгөн гүйлгээний тайлан**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018</b>	<b>2017</b>
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Тайлант жилийн ашиг	<b>16,769,618</b>	<b>58,706,697</b>
Тохируулгууд:		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	96,474	93,182
Биет бус хөрөнгийн хорогдол	231,075	170,908
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	1,703
Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сангийн зардал	51,243,353	-
Авлагын алдагдлын сангийн зардал	1,303,794	13,203,620
Хүүгийн цэвэр орлого	(29,119,548)	(39,471,826)
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>40,524,766</b>	<b>32,704,284</b>
Авлагын бууралт	20,288	212,332
Бусад санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт)/бууралт	(51,639)	2,783
Худалдааны болон бусад өр төлбөрийн (бууралт)/өсөлт	(502)	456
<b>Ажлын капиталын өөрчлөлт</b>	<b>(31,853)</b>	<b>215,571</b>
Хүлээн авсан хүүгийн орлого	29,761,844	38,178,856
Эрх хүлээн авагчаас цуглуулсан авлага	13,000	5,500,401
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>70,267,757</b>	<b>76,599,112</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Үндсэн хөрөнгө худалдан авалт	(76,203)	(40,077)
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт дуусгавар болсоноос хүлээн авсан мөнгөн гүйлгээ	105,084,566	24,604,336
Биет бус хөрөнгө худалдан авалт	(149,863)	(148,365)
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>104,858,500</b>	<b>24,415,895</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Зээлийн эргэн төлөлт	(13,000)	(5,500,401)
Хүүгийн зардлын төлөлт	(592,897)	(557,762)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(605,897)</b>	<b>(6,058,163)</b>
<b>Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>222,889,158</b>	<b>127,932,314</b>
<b>Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>397,409,518</b>	<b>222,889,158</b>

Энэхүү санхүүгийн тайлангийн 9-43 дугаар хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**1. Ерөнхий мэдээлэл**

Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулийг Улсын Их Хурал 2013 оны 1 дүгээр сарын 10-нд баталж, тухайн өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын тухай хуульд 2018 оны 2 дугаар сарын 8-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ хуулийн зорилт нь банкин дахь мөнгөн хадгаламжийг хамгаалах зорилт бүхий албан журмын даатгалын тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Бүх арилжааны банкууд даатгалд хамрагдах үүрэгтэй.

2013 оны 6 дугаар сард Хадгаламжийн Даатгалын Корпораци (цаашид "ХДК" гэх) дээрх хуулийн дагуу арилжааны банкууд дахь мөнгөн хадгаламж (харилцах болон хадгаламжийн данс)-ийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан. ХДК нь иргэний хуулийн дагуу "Сан"-гийн хэлбэрээр зохион байгуулагдсан, ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд юм. Сангийн эхлэлтийн хөрөнгийг Сангийн яам болон Монголбанкнаас оруулсан. Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулиар ХДК-ийн үйл ажиллагааны зорилго, цар хүрээ, удирдлагын бүтцийг тодорхойлж өгсөн. Уг хуулийн дагуу ХДК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон лиценз бүхий арилжааны банкуудаас хадгаламжийн даатгалын хураамжийг төвлөрүүлэх, хуримтлагдсан санг хөрөнгө оруулалт хэлбэрээр өсгөх, банк лицензээ хураалгасан тохиолдолд тухайн банкны хадгаламж эзэмшигчдэд даатгагдсан хадгаламжийн дүнг нөхөн олгох зэрэг юм.

Хэрэв Монголбанк банкыг "албадан татан буулгах" шийдвэр гаргасан тохиолдолд, тухайн банкны хадгаламж эзэмшигчдэд ХДК нь 30 хоногийн дотор даатгалын нөхөн төлбөрийг олгох үүрэгтэй. Нэг хувь хүн эсвэл аж ахуйн нэгжид олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ 20 сая төгрөг байна. Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуульд Монголбанк "Албадан татан буулгах" шийдвэр гаргахыг даатгалын тохиолдол гэж тодорхойлсон. ХДК нь хадгаламж эзэмшигчдэд олгосон даатгалын нөхөн төлбөрийг татан буугдсан банкны хөрөнгийн борлуулалтаас буцаан авах эрхтэй бөгөөд энэхүү дүн нь хадгаламж эзэмшигчдэд олгосон нөхөн төлбөрийн дүнгээр хязгаарлагдана.

ХДК-ийн удирдах дээд байгууллага нь 7 гишүүнээс бүрдэх Үндэсний Хороо байна. Сангийн яам болон Монголбанк тус бүр 2 төлөөлөгч, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ"), Монголын Банкны Холбоо ("МБХ") тус бүр 1 төлөөлөгчтэй. Үүн дээр ХДК-ийн гүйцэтгэх захирал Үндэсний Хорооны гишүүн байна. Эдгээр байгууллагууд нь ХДК-ийн холбоотой тал болох ба холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээг Тодруулга 22-ээс үзнэ үү.

Үндэсний Хорооны шийдвэр нь олонхийн саналд үндэслэдэг бөгөөд гишүүдийн олонх нь Засгийн газрын харьяа байгууллагуудаас томилогддог учир, ХДК нь Засгийн газрын удирдлагад байх бөгөөд Засгийн газар нь түүний удирдах дээд байгууллага болно. Дээрх байгууллагуудын аль нь ч дангаараа ХДК-г удирдах боломжгүй тул ХДК-д шууд толгой байгууллага байхгүй.

ХДК нь ашгийн төлөө бус, төрийн өмчит байгууллага учир улсын болон орон нутгийн татвар төлөхгүй.

ХДК-ийн хаяг: Монгол улс, Улаанбаатар 14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 91, Санроуд Оффис 3 давхар.

## **2. Үйл ажиллагааны орчин**

2017 онд 5.8%-тай байсан манай улсын эдийн засгийн өсөлт хамгийн сүүлийн үеийн байдлаар буюу 2018 оны 4-р улирлын байдлаар 6.2% болж өссөн үзүүлэлттэй байна. Экспортын хэмжээ өсч, зэсийн болон нүүрсний үнийн тогтвортой байдал нь ДНБ-ий өсөлтөд нөлөөлсөн хэдий ч Монгол Улсын эдийн засагтай холбоотой тодорхой эрсдэлүүд байсаар байна. Монгол улс нийт гадаад өрийн хэмжээгээрээ 2018 оны 3-р улирал гэхэд 7.24 тэрбум долларт хүрсэн нь 2017 оны 3-р улиралтай харьцуулахад 12%-аар өссөн байна. БНХАУ-ын эдийн засгийн удаашрал болон экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн бууралт зэрэг хэд хэдэн төрлийн гадаад хүчин зүйлүүд нь бусад боломжит эрсдэлд орно.

Мүүдийг үнэлгээний агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийг 2016 оны 11 дүгээр сарын 18-нд В3-аас Саа1, тогтвортой болгон бууруулсан. 2018 оны 1-р сард Монгол улсын зээлжих зэрэглэлийг Мүүдийг, дараа нь Стандарт энд Пүүрс В3 болгон сайжруулсан.

2017 оны хоёр дугаар улиралд, Олон Улсын Валютын Сангийн ("ОУВС") "Өргөтгөсөн Санхүүжилтын Хөтөлбөр"-т Монгол улс хамрагдахаар болсон. ОУВС-ийн (Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Япон, Солонгос болон БНХАУ-ын дэмжлэгтэй) нийт санхүүжилт нь 3 жилийн хугацаатай 5.5 тэрбум ам.долларын хэмжээтэй. Гадаад валютын дотогш урсгал хангалтгүйгээс төлбөрийн тэнцэл 2012 оноос хойш алдагдалтай байсан бөгөөд, 2016 оны 12 дугаар сарыг хүртэл төгрөгийн ханш ам.долларын эсрэг ихээр суларсан. ОУВС-ийн санхүүжилт зэрэг капиталын дотогш урсгал нэмэгдсэнээр 2017 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч эхэлсэн. 2017 онд Монгол улсын Засгийн газар өөрийн ам.долларын бондыг амжилттай дахин санхүүжүүлснээр гадаад валютын ханш харьцангуй тогтвортой болсон. Түүнчлэн дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан худалдааны тэнцэл сайжирсан нь төсвийн алдагдал 2015 оноос хойш хамгийн бага түвшинд хүрэхэд хүргэсэн. Өргөтгөсөн Санхүүжилтын Хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас Монгол улсын арилжааны банкуудад Активын Чанарын Үнэлгээ (АЧҮ)-г зохион байгуулсан.

Активын Чанарын Үнэлгээний үр дүнд Монголбанкнаас арилжааны банкуудад 2018 оны эцэс гэхэд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх даалгавар өгсөн. Энэхүү санхүүгийн тайлангууд гарах өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн өсөлтийн хэрэгжилтийн байдал үнэлгээний шатандаа явж байна.

Өнөөгийн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн уналт, БНХАУ, Монгол улсын эдийн засгийн өсөлтийн удаашрал, төгрөгийн ам.доллар, еврогийн эсрэг ханшийн уналт болон бусад эрсдэлүүд Монголын банк санхүү, ААН-үүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих зорилгоор ХДК нь макро эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлын төсөөлөл зэрэг ирээдүйг харсан хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдээллүүдийг ашигласан. Гэвч аливаа эдийн засгийн таамаглалын адилаар тэдгээрийн тохиолдох магадлал, төсөөлөл нь тодорхой бус байх өндөр боломжтой бөгөөд тиймээс бодит үр дүн нь мөн төсөөллөөс ихээхэн өөр байх магадлалтай. Тодруулга 18-д ХДК нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт ирээдүйг харсан мэдээллүүдийг хэрхэн ашигласан талаар илүү дэлгэрэнгүй тусгасан.

### **3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого**

**Санхүүгийн тайланг бэлтгэх үндэслэл.** Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх мөн санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээг тайлант үеийн орлого зарлагад бодит үнэ цэнийн дагуу бүртгэх болон бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн дагуу бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэж тайлагнасан болно. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн гол бодлогуудыг доор харууллаа. 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон СТОУС 9 болон СТОУС 15-ыг хэрэгжүүлэх болсны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн бодлого өөрчлөгдсөнөөс тэдгээр бодлогууд нь өөрөөр илэрхийлэгдэхээс бусад тохиолдолд толилуулсан тайлангийн бүх хугацаануудад нийцтэй хэрэглэгдсэн.

**Гадаад валютын хөрвүүлэлт.** Санхүүгийн тайланг өөрөөр заагаагүй бол Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол Төгрөгөөр илэрхийлсэн болно. ХДК-ийн бүртгэлийн валют нь Монгол Төгрөг юм.

**Санхүүгийн хэрэглүүрүүд – Үндсэн нэр томъёо.** Бодит үнэ цэнэ гэдэг нь хөрөнгийг борлуулахад хүлээн авах үнэ эсвэл хэмжилтийн өдөр өр төлбөрийг шилжүүлэхийн тулд зах зээлд оролцогчдын хоорондын хэлцлээр төлөх үнэ байна. Идэвхтэй зах зээл дээрх үнэ нь бодит үнэ цэнэд хамгийн ойр байна. Идэвхтэй зах зээл гэдэг нь тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хэлцэл хангалттай давтамж, хэмжээгээр явагдаж үнийн талаарх мэдээлэл тогтмол олдох боломжтой зах зээлийг хэлнэ.

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тухайн хөрөнгийн худалдаалагдаж буй үнийг ХДК эзэмшиж байгаа тоо хэмжээгээр үржүүлж тооцоолно. Зах зээлийн хэвийн өдөр тутмын арилжааны хэмжээ нь ХДК-ийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй бага байх, эсвэл тодорхой ганц хэлцэл худалдаалагдаж буй үнэд нөлөөлөх үед ч мөн адил дээрх байдлаар тооцоолно.

Идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй санхүүгийн дериватив болон бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн багцыг хэмжихдээ бүлэг санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг ашиглана. Ингэхдээ тодорхойлох өдрийн байдлаар зах зээлд оролцогчдын хооронд тухайлсан эрсдэлийн дүнгийн хувьд цэвэр урт позицийг (өөрөөр хэлбэл хөрөнгө) зарахад хүлээн авах үнэ эсвэл цэвэр богино позицийг (өөрөөр хэлбэл өр төлбөр) шилжүүлэхэд төлөх үнэд суурилна. Энэ нь давтагдах байдлаар бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгийн хувьд хамааралтай ба ХДК (а) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг зах зээлийн тодорхой эрсдэлийн хувьд эсвэл байгууллагын баримтжуулсан эрсдэлийн удирдлага болон хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тодорхой талын зээлийн эрсдэлийн хувьд удирддаг бол (б) Хөрөнгө болон өр төлбөрийн мэдээллийг гол удирдлагад мэдээллэдэг бол (в) тухайн байгууллагын зах зээлийн тодорхой эрсдэл (эсвэл эрсдлүүд)-д өртөх байдал, санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөртэй холбоотой гарах зах зээлийн тодорхой эрсдлүүд нь үндсэндээ ижил бол тус тус хамааралтай байна.

Гадаад зах зээлийн мэдээлэл авах боломжгүй тохиолдолд санхүүгийн тодорхой хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо хорогдуулсан мөнгөн урсгалын загвар, сүүлийн үеийн ижил төстэй хэлцэлд ашигласан загвар болон хөрөнгө оруулсан талын санхүүгийн тайлан мэдээг ашиглах зэрэг үнэлгээний аргачлалыг ашиглана. Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрт тодорхойлох ба эдгээр түвшин нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Тайлант хугацааны эцэст бодит үнэ цэнийн түвшин хооронд шилжилт явагдсан гэж үзнэ.

**Ажил гүйлгээний өртөг** нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой өсөн нэмэгдэх зардлууд юм. Өсөн нэмэгдэх зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал юм. Ажил гүйлгээний өртөгт агент (борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн эрх шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Ажил гүйлгээний өртөгт өрийн хэрэглүүрийн хямдруулалт, урамшуулал, санхүүжилтын зардлууд, дотоод удирдлага, захиргааны буюу хадгалалтын зардлууд орохгүй.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

*Хорогдуулсан өртөг* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй алдагдлыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүнд ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний өртгийн хорогдуулалт, мөн үр ашигт хүүгийн аргаар тооцсон аливаа урамшуулал болон хөнгөлөлтийн дүн багтана. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон хорогдуулсан урамшуулал буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулахгүйгээр дансны үнэд оруулан толилуулна.

*Үр ашигт хүүгийн арга* нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн төвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм урамшуулал, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Санхүүгийн хөрөнгийг анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан үед анх хүлээн зөвшөөрөхдөө үр ашигт хүүгийн хэмжээг зээлийн эрсдэлийг харгалзан үзэж тохируулдаг, жишээ нь: гэрээнд заасан мөнгөн урсгал бус хүлээгдэж буй мөнгөн урсгалд тулгуурлан авч үзнэ.

**Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт.** Бодит үнэ цэнийг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд анх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бусад бүх санхүүгийн хэрэгслийг анхны бодит үнэ цэнийг ажил гүйлгээний өртгөөр тохируулга хийсэн дүнгээр бүртгэдэг. Анх бүртгэх үеийн бодит үнэ цэнэ нь гүйлгээ хийгдсэн үнээр баталгаажсан байдаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан бөгөөд үүнийг зөвхөн ижил төстэй хэрэгслийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа хүлээгдэж буй зээлийн алдагдлын ("ХЗА") санг хорогдуулсан өртгөөр бүртгэж хэмжих санхүүгийн хөрөнгө болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтад хүлээн зөвшөөрөх ба энэ нь нягтлан бодох бүртгэлд алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("хэвийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу ХДК нь тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг ХДК нь санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн ангилал.** ХДК нь санхүүгийн хөрөнгийг хэмжилтээр нь дараах төрлүүдэд ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ ("ААБҮЦ"), Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ ("БДОБҮЦ") болон Хорогдуулсан өртөг ("ХӨ"). Өрийн хэлбэрээрх санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) ХДК-ийн хөрөнгүүдээ удирдах бизнесийн загвар (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес загвар.** Бизнес загвар нь ХДК нь санхүүгийн хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл ХДК-ийн зорилго нь (i) зөвхөн тухайн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль ч тохиолдол биш бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээг хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд ХДК-ийн хийж буй үйл ажиллагаанд хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн бүлэг

### **3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн бизнес загварыг тодорхойлоход ХДК-ийн авч үзэх хүчин зүйлүүдэд багцын зорилго болон бүтэц, тухайн хөрөнгөнөөс ирэх мөнгөн урсгалыг хэрхэн цуглуулдаг талаарх өнгөрсөн туршлага, эрсдэлээ хэрхэн үнэлж удирдаж байгаа, тухайн хөрөнгийн гүйцэтгэлд хэрхэн үнэлгээ хийж, удирдаж байгаа мөн удирдлагыг хэрхэн урамшуулж байгаа зэрэг орно.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог.** Бизнес загвар нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлбөрөөс бүрдэж буй (ЗХҮТ) эсэхэд ХДК нь үнэлгээ өгнө. Энэ үнэлгээг хийхдээ гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд тогтвортой эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхэд үнэлгээ өгнө.

Гэрээний нөхцлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. ЗХҮТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй. Санхүүгийн хөрөнгүүдэд ЗХҮТ шалгалт хийхэд ХДК-ийн ашигласан үнэлэлтүүдийг тодруулга 4-өөс үзнэ үү.

**Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал.** Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараа хамгийн эхний тайлагналын үеийн эхнээс хэрэгжинэ. ХДК нь тайлант жил болон түүний өмнөх жилд бизнес загвараа өөрчлөөгүй бөгөөд аливаа дахин ангилал хийгээгүй болно.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - Хүлээгдэж буй зээлийн алдагдлын сан.** ХДК нь хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн өрийн хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй алдагдлыг үнэлэхдээ ирээдүйд чиглэсэн мэдээллийг харгалзан үздэг. ХДК нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг ("ХЗА") хэмжиж, алдагдлын зардлыг тайлант хугацаа бүрт хүлээн зөвшөөрдөг. Хүлээгдэж буй алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жигнэсэн дүн; (ii) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг Санхүүгийн байдлын тайланд ХЗА-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээрх өрийн хэрэглүүрийн хувьд хорогдуулсан өртгийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бусад дансны үнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тайлагнадаг.

ХДК нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүд нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын зээлүүдийн ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХЗА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв ХДК нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д ангилах бөгөөд ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх буюу эргэн төлөлтүүдийг харгалзан үзсэний дараах гэрээ дуусах хүртэлхи хугацааг харгалзан үзнэ (Ашиглалтын хугацааны ХЗА). Тодруулга 18-д ХДК нь зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн хэрхэн тодорхойлдог талаар тайлбарласан. Хэрэв ХДК нь тухайн санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнэ буурсан гэж үзвэл "3-р шатлал"-д ангилах бөгөөд ашиглалтын хугацааны турш дахь ХЗА-г тооцдог. Санхүүгийн хөрөнгийг анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан үед ХЗА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дахь ХЗА-тай ижил хэмжигдэнэ. ХЗА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээллүүд, таамаглал болон тооцооллын аргуудыг мөн ХДК нь ХЗА загварт ирээдүйг харсан мэдээллүүдийг хэрхэн ашигласан талаар илүү дэлгэрэнгүйг Тодруулга 18-аас үзнэ үү.

ХДК-ийн авлагын хэмжээ бага тул санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд тусгай үнэлгээ хийсэн.

**Санхүүгийн хөрөнгө – Данснаас хасах.** ХДК нь аливаа санхүүгийн хөрөнгийг сэргээх бүх хүчин

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

чармайлтаа дуусгаж нөхөн сэргэх ямар ч боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд бүтнээр болон хэсэгчилсэн байдлаар данснаас хасдаг. Данснаас хасах нь бүртгэлээс хасаж байна гэсэн үг юм. ХДК нь аливаа хөрөнгөд нөхөн сэргээгдэнэ гэсэн ямар ч таамаглал байхгүй тохиолдолд ч тухайн хөрөнгийн гэрээний дагуу төлөгдөх дүнг нөхөхийн тулд албадан сэргээх үйл ажиллагаа явуулж болдог.

**Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах.** ХДК нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй.

Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

**Санхүүгийн хөрөнгө - Өөрчлөлт.** ХДК нь санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцоо тохиолдол гардаг. ХДК нь гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, (ялангуяа ашгийн хуваарилалт эсвэл өмчийн өгөөж), хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, валютын өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үе дэх зээлийн сунгалт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож ХДК нь анхны санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасаж бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болон зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзэх өдөр болно. Мөн ХДК нь шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Данснаас хассан анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь харилцагч талаын санхүүгийн хүндрэлтэй болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд ХДК нь хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөд эрсдэл болон ашиг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон ашиг өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн бүртгэлээс хасахгүй.

ХДК нь анхны үр ашигт хүүгийн түвшинг ашиглан өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал.** Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрүүдийг дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэнэ.

**Санхүүгийн өр төлбөр – бүртгэлээс хасах.** Санхүүгийн өр төлбөр нь төлж барагдуулснаар бүртгэлээс хасагдана (мөн гэрээгээр хүлээсэн үүрэг нь хүчингүй болсон цуцлагдсан үед бүртгэлээс хасагдана).

ХДК болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл бүхий өрийн хэрэглүүр, болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг данснаас хасаж шинэ санхүүгийн өр төлбөр бүртгэх үндэслэл болно. Шинэ нөхцлөөрх мөнгөн гүйлгээний аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн урсгалын хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр



### **3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

үгүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн олз гарз болно. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамж зардал нь өр төлбөрийн дансны үнэд нэмэгдэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацаанд ноогдуулан хорогдуулж тооцно.

Дансны үнийн өөрчлөлтийн эдийн засгийн шинж чанар нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд өрийн хэрэглүүрт хийсэн өөрчлөлтийг хуримтлуулах аргыг ашиглан ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн өр төлбөр – ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх.** ХДК тодорхой өр төлбөрүүдийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрч болно. Тухайн өр төлбөрүүдээс үүссэн олз гарз нь өр төлбөрийн зээлийн эрсдэлийн өөрчлөлттэй холбоотой үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт (бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэд бүртгэгддэг, дараа нь ч орлого зарлагаарх бодит үнэ цэнэд ангилагдахгүй) -ийн дүнгээс бусад хэсгийг ашиг алдагдалд тайлагнана. Тус толилуулга нь нягтлан бодох бүртгэлийн зөрүү үүсгэж, уг зөрүүг ихэсгэхгүй бол өр төлбөрийн зээлийн эрсдэлд өөрчлөлт орсноор үүссэн олз гарзыг ашиг алдагдалд тайлагнана.

**Санхүүгийн хэрэгслүүрүүдийг хооронд нь хаах.** Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Эдгээр хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох ямар нэгэн үйл явдлаас хамааралгүй байх, мөн (б) доорхи нөхцөл байдалд хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх ёстой. Үүнд: (i) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед, (ii) дампуурах үед, мөн түүнчлэн (iii) төлбөрийн чадваргүй болсон үед.

**Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт.** Хувьцаа гаргагчийн хувьд өмчийн тодорхойлолтод нийцэх санхүүгийн хөрөнгийг ХДК-ийн хувьд өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт гэж үзнэ, жишээ нь бэлэн мөнгөөр төлөх гэрээний үүрэг хариуцлагыг агуулаагүй хэрэгсэл мөн хувьцаа гаргагчийн цэвэр хөрөнгөд ашиг сонирхол нь байгаа гэдгийг нотлох хэрэгсэл. ХДК нь өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг анхлан хүлээн зөвшөөрөхдөө бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжин, хэмжилтийн сууриа ахин өөрчлөхгүй гэж шийдсэнээс бусад ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ. ХДК-ийн бодлогод өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжихийн тулд эдгээр хөрөнгө оруулалтууд нь зөвхөн хөрөнгө оруулалтын үр ашгийг хүртэх гэхээсээ илүү стратегийн зорилготой байна гэж заасан. Хэрэв бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ хэмээн заасан бол бодит үнэ цэнийн өөрчлөлт болон борлуулах үеийн олз гарз нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд ашиг, алдагдалд дахин ангилагдахгүйгээр тусгагдана. Үнэ цэнийн бууралтын гарз үүсвэл үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. ХДК нь төлбөр хүлээн авах эрхтэй болох үед ногдол ашгийг хөрөнгө оруулалтын өгөөж гэхээс илүү хөрөнгө оруулалтын буцаан төлөлт байдлаар авахаас бусад тохиолдолд ногдол ашиг нь ашиг алдагдлаарх тайланд хүлээн зөвшөөрөгдөгдөнө.

**Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь хугацаагүй хадгаламж ба 3 сар болон түүнээс бага хугацаатай бусад богино хугацаат хөрвөх чадвар сайтай хөрөнгө оруулалтууд багтана. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь (1) бизнес загварын хувьд гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдэж байгаа (2) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэхээр заагдаагүй тул хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн. Эдгээр шинж чанаруудыг зөвхөн хууль тогтоомжоор баталгаажуулсан ба жишээлбэл зарим улсад байдаг "Bail in" хуулийн адил тухайн хууль тогтоомж өөрчлөгдсөн ч тухайн гэрээний нөхцөл өөрчлөгдөхгүй гэж заагаагүй бол ЗХҮТ-ийн шалгуурт нөлөө үзүүлэхгүй.

**Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнэ бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа нэмж гарсан зардлыг, зөвхөн уг зардалтай холбогдох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж ХДК-д орж ирэх магадлалтай ба зардлыг хэмжих боломжтой үед л хөрөнгийн дансны үнэд багтаах буюу тохиромжтой гэж үзвэл тусдаа хөрөнгө гэж бүртгэнэ.

**3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

Засвар үйлчилгээтэй холбоотой өдөр тутмын жижиг зардлуудыг тухай бүрт нь зарлагаар бүртгэнэ. Хөрөнгийн томоохон эд анги, хэсгийг солих зардлыг капиталжуулж, хуучин эд ангийг актална.

Тайлант хугацааны эцэс бүрт удирдлага үндсэн хөрөнгөд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв бууралт байгаа шинж тэмдэг ажиглагдвал, удирдлага нөхөн сэргээгдэх дүн буюу хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль ихийг тооцоолно. Дансны үнийг нөхөн сэргээгдэх дүнтэй тэнцүүлэн бууруулж үнэ цэнийн бууралтыг тайлант хугацааны алдагдлаар бүртгэдэг. Хэрэв хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх тайлант хугацаануудад хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтыг буцаалт хийнэ.

Борлуулалтын олз гарз нь борлуулсан дүн ба дансны үнийн зөрүүгээр тайлант хугацааны ашиг алдагдалд бүртгэгдэнэ.

**Элэгдэл.** Үндсэн хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн үлдсэн ашиглагдах хугацаанд хуваарилан шулуун шугамын аргаар тооцоолно:

Оффисын тавилга	- 10 жил
Автомашин	- 10 жил
Тоног төхөөрөмж	- 3 жил

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, хуучирсан гэж үзвэл ХДК одоо худалдаж болох үнээс худалдан борлуулахтай холбогдон гарах зардлыг хассан дүнг хэлнэ. ХДК үндсэн хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг тайлант жил бүрийн эцэст эргэн хянаж, шаардлагатай тохиолдолд өөрчилнө.

**Гүүдвилээс бусад биет бус хөрөнгүүд.** Гүүдвилээс бусад ХДК-ийн биет бус хөрөнгүүд нь тодорхой ашиглалтын хугацаатай бөгөөд үүнд голчлон капиталжуулсан компьютерийн програм хангамжийг оруулдаг. Шинээр авч буй компьютерийн программ хангамжийн лицензүүдийг худалдан авах мөн тэдгээрийг ашиглалтанд оруулах хүртэлх гарсан зардлуудыг оруулан капиталжуулна. Биет бус хөрөнгүүдийг ашиглалтын хугацааных нь дагуу шулуун шугамын аргаар хорогдуулна. Хэрэв үнэ цэнэ буурвал, биет бус хөрөнгийн дансны үнийг тухайн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгийн аль ихрүү нь бууруулж бичнэ.

**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт.** Ашиглагдах хугацаа нь тодорхой бус эсвэл ашиглагдахад бэлэн болоогүй биет бус хөрөнгийг хорогдуулахгүй бөгөөд жил бүр үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг шалгадаг. Элэгдэл болон хорогдол байгуулдаг хөрөнгийн хувьд дансны үнэ нь нөхөгдөх боломжгүй байж болохыг илтгэх нөхцөл байдал үүсэх бүрт үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг шалгадаг. Хөрөнгийн дансны үнэ түүний нөхөгдөх өртгөөс хэтэрсэн хэмжээгээр үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх өртөг нь хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль их нь байна. Үнэ цэнийн бууралтыг үнэлэх зорилгоор, хөрөнгүүдийг бие даан мөнгөн урсгал бий болгох хамгийн бага бүлэг хөрөнгө (мөнгөн урсгал бий болгогч нэгж) болгон хуваадаг. Тайлант хугацааны эцэс бүрт санхүүгийн бус хөрөнгийн өмнөх үнэ цэнийн бууралтыг буцаалт хийх боломжтой эсэхийг шалгадаг.

**Худалдааны болон бусад өр төлбөр.** Худалдааны өр төлбөр нь холбогдох тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үед аккруэл хийгдэх бөгөөд анх бодит үнэ цэнээр бүртгэгдэж цаашид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ.

**Болзошгүй өр төлбөрийн нөөц сан.** Энэ нь өр төлбөрийн цаг хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. ХДК-д өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулийн дагуу, эсвэл хууль эрх зүйн дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон, мөн уг үүрэг хариуцлагыг шийдвэрлэх явцад эдийн засгийн өгөөж агуулсан зарлагын урсгал гарах өндөр магадлалтай болон энэхүү үүргийг хүлээх нь найдвартай тооцоологдож, мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой болсон тохиолдолд нөөцийн санг тооцож бүртгэнэ.

**Монголбанкнаас авсан зээл.** Зээлийг анхлан бодит үнэ цэнээр нь буюу ажил гүйлгээний өртгийг оруулан цэвэр дүнгээр бүртгэлд тусгах ба дараа үеийн хэмжилт нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд авсан зах зээлийн

### **3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

түвшнээс доогуур хүүтэй зээлийн хувьд анхлан хүлээн зөвшөөрөлтийн олзыг бүртгэнэ. Зах зээлийн түвшнээс доогуур хүүтэй авсан зээлийн тухай болон холбогдох удирдлагын үнэлэмжийн талаар дэлгэрэнгүйг Тодруулга 4 болон 12-с харна уу.

**Оруулсан хөрөнгө.** Оруулсан хөрөнгө нь Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуульд тодорхойлогдсон ХДК-ийн сан бөгөөд харгалзах өдрөөрх бүртгэлтэй өөрийн хөрөнгүүд багтана (Тодруулга 17-ыг үзнэ үү).

**Даатгалын хураамжийн орлого.** Хадгаламжийн даатгалын хураамжийн орлого нь Монголбанкны лиценз бүхий арилжааны банкуудаас ХДК-д төлсөн эхлэлтийн болон ба жил бүрийн даатгалын хураамжаас бүрдэнэ.

Даатгалын хураамж нь хуулийн дагуу хураамж төлөгдөх ёстой өдрөөр бусад дэлгэрэнгүй орлогын тайланд (тайлант хугацааны үр дүнд) хүлээн зөвшөөрөгдөнө.

ХДК нь орлогыг хүлээн зөвшөөрөхдөө хэмжээг тодорхойлох боломжтой, ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг ХДК хүлээн авах магадлалтай бөгөөд ХДК-ийн үйл ажиллагаа бүрт тодорхой шалгуур хангагдсан нөхцөлийг харгалзан үзнэ.

**Хүүгийн орлого.** Хүүгийн орлогыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжигдэхээс бусад бүх өрийн хэрэглүүрийн хувьд аккруэль суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх шимтгэл хураамж, урамшуулал болон хямдруулалтыг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлогод бүртгэдэг.

**Засгийн газрын буцалтгүй тусламж.** Монголбанкнаас зах зээлийн хүүгээс бага хүүтэй авсан зээлийг Засгийн газрын буцалтгүй тусламж гэж бүртгэлд тусгана. Засгийн газрын буцалтгүй тусламжийг тухайн тусламжийг хүлээн авах үндэслэлтэй баталгаа байгаа, мөн ХДК заасан бүх нөхцлийг дагаж мөрдөх нь тодорхой болсон үед бодит үнэ цэнээр бүртгэнэ. Зах зээлийн хүүгээс бага хүүгийн түвшний ашгийг (ө.х зээлийг анх хүлээн зөвшөөрөх үеийн олз) СТОУС 9-ийн дагуу тооцоолсон зээлийн анхны дансны үнэ болон хүлээн авсан мөнгөний зөрүүгээр тодорхойлох бөгөөд Засгийн газрын буцалтгүй зээлийн орлого гэж бүртгэнэ. Уг орлогыг зээлийн хугацааны турш хойшлуулах эсвэл НББОУС 20-ийн нөхцлүүд хангагдаж буй тохиолдолд (ө.х Монголбанкны санхүүжилтээр анх авлага хүлээн зөвшөөрөх үед гарз үүссэн үед) шууд тайлант хугацааны ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө. Зээлийн хугацааны турш хойшлуулагдах тохиолдолд холбогдох буцалтгүй тусламжийн орлого нь ашиг алдагдалд үр ашигт хүүг ашиглан системтэйгээр хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд хүүгийн зардалтай хаагдана.

Холбогдох буцалтгүй тусламжийн орлого ба анх хүлээн зөвшөөрөгдөх үеийн гарзыг ашиг алдагдалд шууд хүлээн зөвшөөрөх тохиолдолд, буцалтгүй тусламжийн орлого (ө.х анх хүлээн зөвшөөрөгдөх үеийн олз) нь холбогдох анх хүлээн зөвшөөрөх үеийн гарзтай хаагдана. Зээлийн хүүгийн зардал ба холбогдох авлагын хүүгийн орлогыг үр ашигт хүүг ашиглан системтэйгээр хооронд нь хаана.

**Үйл ажиллагааны түрээс.** ХДК нь түрээсийн гэрээнд түрээслэгчээр оролцож, өмчлөлийн ихэнх эрсдэл болон урамшуулал нь түрээслүүлэгчээс ХДК-д шилжин ирээгүй тохиолдолд түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилж тухайн тайлант жилийн ашиг алдагдалд (түрээсийн зардлаар) бүртгэнэ.

**Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт.** Хүүгийн зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэль суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг ерөнхийдөө аккруэль суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

**Ажиллагсдын зардал болон холбогдох шимтгэлүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг ХДК-ийн ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт болон нөхөн олговортой бусад богино хугацаат хуримтлагдах чөлөө авалтыг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед,

### **3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого (Үргэлжлэл)**

нөхөн олговортой богино хугацаат хуримтлагдахгүй чөлөө авалтыг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авалтыг) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого, зарлагад зардлаар бүртгэдэг. Энд дурьдсан улсын тогтмол шимтгэлтэй сангуудад болон тогтмол шимтгэлтэй хөтөлбөрт төлдөг төлбөрүүдээс гадна ХДК нь өөр ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмжийн төлбөр хийх хууль эрх зүйн буюу зохиомол үүрэг хүлээгээгүй болно.

**Санхүүгийн тайлангуудыг батлан гаргасны дараах нэмэлт засвар.** ХДК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг батлан гаргасны дараа нэмэлт засвар хийх эрхтэй.

### **4. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон хэмжилтийн суурь**

СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлангууд бэлтгэхтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцад санхүүгийн тайланд толилуулагдсан хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлын дүнд нөлөөлөхүйц үнэлэмж, тооцоолол, болон таамаглалыг удирдлагын зүгээс хийх шаардлагатай байдаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно. Тооцоолол болон таамаглалуудыг тогтмол эргэн харж, хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг ирээдүйд мөрдөх горимыг баримтлан бүртгэлд тусгана.

ХДК нь тайлант хугацаанд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүд болон хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд нөлөөлөх таамаглал болон тооцооллуудыг хийдэг. Эдгээр таамаглал болон тооцооллуудыг тогтмол дахин хянадаг бөгөөд ингэхдээ удирдлагын туршлага болон тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй гэж үзсэн ирээдүйн үйл явдлын талаарх хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдийг суурь болгон авч үздэг.

**Монголбанкнд төлөх зээл болон холбогдох хөрөнгийн бүртгэл.** Төрийн банк нь Хадгаламж банктэй нэгдсэний дараа санхүүгийн туслалцаа үзүүлэхийн тулд ХДК нь Монголбанкнаас жилийн 0.5 хувийн хүүтэй 119.9 тэрбум төгрөгийн зээл, 85 тэрбум төгрөгийн хүүгүй зээлийг авсан (Тодруулга 12). Эдгээр зээлийг ХДК нь Төрийн банкинд санхүүгийн туслалцаа үзүүлэх нөхцөлтэйгөөр зах зээлийн хүүгийн түвшнээс бага хүүтэй авсан. Монголбанк, Засгийн газартай байгуулсан дээрх хэлцлүүдийн дүнд ХДК нь Хадгаламж банкны Эрх Хүлээн Авагч болон Засгийн Газраас авах хүүгүй авлага (Тодруулга 9) болон Төрийн банкинд өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт (Тодруулга 10) бүртгэсэн. Зээлийг тодорхой зориулалтын дагуу ашиглах нөхцөлтэй учир Монголбанкнаас олгосон зээлүүд нь НББОУС 20-ийн дагуу Засгийн газрын буцалтгүй тусламж ангилалд багтана.

ХДК-ийн удирдлага нь Монголбанкны бодлогын хүү болох жилийн 10.5 хувийг төгрөгийн эх үүсвэрийн зах зээлийн хүүтэй хамгийн ойролцоо байна гэж үзэн дээрх зээлүүдийг анх хүлээн зөвшөөрөх үед холбогдох олзыг хүлээн зөвшөөрсөн.

119,9 тэрбум төгрөгийн зээлийн хувьд анх хүлээн зөвшөөрөх үеийн олз нь 30,722,699 мянган төгрөг байсан ба (Монголбанкны бодлогын хүү жилийн 10.5 хувийг ашиглан тооцсон) Хадгаламж банкны эрх хүлээн авагчаас авах авлагын анх хүлээн зөвшөөрөх үеийн гарзтай хаагдсан. Анх хүлээн зөвшөөрөх үеийн гарз нь анх хүлээн зөвшөөрөх үеийн олзтой, мөн тайлант үе бүрийн хүүгийн орлого болон зардлуудыг зах зээлийн хүүгийн түвшин дээр үндэслэн тодорхойлсон тул ХДК-ийн 2013 оны 6 дугаар сарын 30-наас 2018 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилүүдийн Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй болно.

85 тэрбум төгрөгийн зээлийн хувьд анх хүлээн зөвшөөрөх үеийн олз болох 10,328,810 мянган төгрөг нь хэлцэл хийгдсэн өдөр (ө.х Монголбанкнаас зээл хүлээн авсан өдөр) хойшлогдсон буцалтгүй тусламжийн орлогоор бүртгэгдэх ба улмаар зээлийн хугацааны турш үр ашигт хүүгийн аргаар системтэйгээр ашиг алдагдалд бүртгэгдэнэ. Иймд ХДК нь 2014 онд 8,368,691 мянган төгрөг, 2013 онд 1,960,119 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийн орлого хүлээн зөвшөөрсөн. Буцалтгүй тусламжийн орлого нь хүүгийн зардалтай ойролцоо дүнтэй бөгөөд харилцан хаагдсан тул 2013-2018 оны ХДК-ийн Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайланд материаллаг нөлөөгүй. Засгийн газрын буцалтгүй тусламжийн талаарх ХДК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3-аас үзнэ үү.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХДК нь Эрх Хүлээн Авагчаас зөвхөн 11,164,000 мянган төгрөгийг хүлээн аваад буй бөгөөд, Монголбанкны зүгээс Эрх Хүлээн Авагчийн хугацааг 2019 оны 12

**4. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон хэмжилтийн суурь (Үргэлжлэл)**

дугаар сарын 31 хүртэл сунгах шийдвэр гаргасан. Удирдлага нь Эрх Хүлээн Авагчаас авах авлагын хүлээгдэж буй алдагдлын санг дахин үнэлэхдээ 2019-2020 оны хооронд хийгдэх Төрийн банкны хувьчлалын асуудлыг харгалзан үзсэн. Энэхүү шийдвэрийг гаргахдаа удирдлага нь 2018 оны 5 сарын 23-ны Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцэгдсэн бөгөөд дараагийн УИХ-ын чуулганаар танилцуулагдах "Төрийн өмчит компани/банкуудыг 2018-2020 онд хувьчлах" тухай УИХ-ын тогтоолын саналыг харгалзаж үзсэн. Дахин тооцооллын үр дүнд СТОУС 9-ын дагуу ХДК нь 2018 оны 1 дүгээр сарын 1 болон 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэмэлтээр 12,386,180 мянган төгрөг болон 1,303,794 мянган төгрөгөөр хүлээгдэж буй алдагдлыг тус тус хүлээн зөвшөөрсөн.

**Төрийн банкин дахь хөрөнгө оруулалтын хяналтын талаарх үнэлгээ болон хэмжилт.** Тодруулга 10-т толилуулснаар 2013 оны 9 дүгээр сард ХДК нь Төрийн банкны хувьцааны 75 хувийг худалдан авсан. Хувьцаа худалдан авах гэрээний дагуу ХДК нь хувьцаа эзэмшигчийн хурал дахь саналын эрх болон Төлөөлөн Удирдах Зөвлөл дэх төлөөллийн болон саналын эрхээ Сангийн яаманд итгэмжлэн шилжүүлсэн тул Төрийн Банкинд хяналт байхгүй гэж удирдлага үзсэн. Мөн ХДК-ийн удирдлага дээрх итгэмжлэх эрхийг буцаах боломжгүй, ХДК нь Төрийн банкны гол стратеги, санхүүгийн үйл ажиллагаанд оролцдоггүй болон Сангийн яамнаас Төрийн банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлд сууж буй төлөөлөгчид ХДК-ийн ашиг сонирхлыг төлөөлж буй эсэхэд баталгаа өгөх боломжгүй зэргийг анхаарч үзсэний үндсэн дээр дээрх дүгнэлтэнд хүрсэн. Түүнчлэн Төрийн Банкны стратегийг тодорхойлоход ХДК нөлөөлөх боломжгүйн дээр Төрийн Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн санхүү, үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох боломжгүй учир удирдлага нь ХДК Төрийн банкинд нөлөөгүй гэж үзсэн. Улмаар ХДК болон Төрийн Банк хоорондын материаллаг хэлцэл нь Төрийн Банкны санхүү, үйл ажиллагааны бодлогын шийдвэрт ХДК нөлөөтэй болохыг илэрхийлэхгүй.

Иймээс, ХДК-ийн удирдлага нь Төрийн банкин дахь хөрөнгө оруулалт нь СТОУС-ын дагуу хараат эсвэл охин компани биш, харин ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх өмчийн хэрэглүүлээрх хөрөнгө оруулалт гэж дүгнэсэн.

Төрийн Банк болон бусад Монголын банкуудын хувьцаа нь нээлттэйгээр хөрөнгийн бирж дээр арилжаалагддаггүй нь Төрийн Банк дахь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлох найдвартай мэдээлэл байхгүйд хүргэсэн тул удирдлага нь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлоходоо цэвэр хөрөнгө дээр суурилсан аргыг ашигласан. Тус үнэлгээнд Төрийн банкны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайлангууд болон банктай холбоотой бусад бүх боломжит мэдээллүүд мөн Монголын банкны секторын нөхцөл байдал зэрэг хүчин зүйлүүдийг ашигласан. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн дагуу Төрийн банк нь 2018 оны 12 сарын 31-ний байдлаар ашигтай ажилласан бөгөөд нийт цэвэр хөрөнгийн хэмжээ 208,156,400 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 31-ний байдлаар 256,854,018 мянган төгрөг байсан. Тооцоололд нийт цэвэр хөрөнгийн дүнгийн 75%-г Эрх Хүлээн Авагчаас авах авлагатай нийлүүлэн тооцоолсон. Үр дүнд ХДК нь 2018 оны 1 сарын 1 болон 2018 оны 12 сарын 31-ний байдлаар 12,386,180 мянган төгрөг болон 1,303,794 мянган төгрөгийн хүлээгдэж буй алдагдлыг Эрх Хүлээн Авагчаас авлага дээр тус тус нэмэлтээр хүлээн зөвшөөрсөн бөгөөд өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтын хувьд бодит үнэ цэнийн тохируулга хийх шаардлагагүй гэж үзсэн. Хэрэв Төрийн Банкны санхүүгийн үзүүлэлтүүд болон цэвэр хөрөнгө нь санхүүгийн тайлангуудад тайлагнаснаас ялгаатай байвал өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэд тохируулга хийх тохиолдол үүсэх боломжтой.

**Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт.** ХЗА-ын хэмжилт нь арга зүй, загвар, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох зэргийг багтаасан чухал тооцоолол байна. ХЗА-ын хэмжилтын арга зүйн дэлгэрэнгүйг Тодруулга 18-аас харна уу. Зээлийн алдагдлын санд дараах бүрэлдэхүүнүүд чухал нөлөөтэй: дефолтын тодорхойлолт, зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт ("SICR"), дефолт болох магадлал ("PD"), дефолт болсон үеийн дүн ("EAD"), дефолт болох үеийн алдагдлын хэмжээ ("LGD") болон макро эдийн засгийн нөхцөлүүд. ХДК нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол болон бодит зээлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах модел болон түүнд ашиглах өгөгдлүүдийг байнга хянаж, баталгаажуулж байдаг. ХДК нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ олон улсын зээлийн үнэлгээний агентлагуудын мэдээллийг ашигладаг бөгөөд зээлийн үнэлгээнд ирээдүйг харсан таамаглалууд багтсан байдаг гэсэн дүгнэлтийг харгалзан үзсэн. ХДК нь нэг хувилбарын загвартаа 45%-ийн LGD-г ашигласан. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар LGD-г 10% -иар өсгөх болон бууруулахад хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжээ 1,087,360 мянган төгрөгөөр өсч буурна.

#### **4. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон хэмжилтийн суурь (Үргэлжлэл)**

**Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR).** Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд ХДК нь тайлант үеийн эцэст санхүүгийн хэрэглүүрүүдийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна. Тайлант хугацааны эцэст ийнхүү үнэлэхдээ тодорхой нэг эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. ХДК нь санхүүгийн хэрэгсэл тус бүрийн түвшинд зээлийн эрсдэлийн үнэлгээ хийж алдагдлыг тогтоохоосоо өмнө зээлийн эрсдэлийн өсөлтийн мөн чанарын үзүүлэлтүүдийг олж тогтоодог. Тодруулга 18 -г харна уу.

Санхүүгийн бүх хөрөнгүүдийн хувьд ашиглалтын хугацааны турш дахь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцвол (үүнд одоогийн байдлаар шатлал 1-д байгаа бөгөөд 12 сарын ХЗА-г тооцоолсон хөрөнгүүдийг оруулан) хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжээ 2018 оны 12 сарын 31-ний байдлаар 128,927 мянган төгрөгөөр ихэснэ. (2018 оны 1 сарын 1-ний байдлаар тооцвол 227,852 мянган төгрөгөөр их)

**Бизнес загварын үнэлгээ.** Бизнес загвар дээрээс үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага нь бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэглүүрүүдийн багц болон түвшинг харгалзан үзэж үнэлэмж өгсөн. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ ХДК нь түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны тухай хүлээлт зэргийг авч үздэг. Зээл чанаргүйдсэнээс үүдэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ нь “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн загвартай таарч байна. Зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй бусад хугацаанаас өмнөх борлуулалтууд дангаараа болон бүлгээрээ олон давтамжтай биш эсвэл үнийн дүнгийн хувьд их биш гэдгийг харгалзан “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн загвартай таарч байна. Мөн түүнчлэн зөвхөн стрессийн тохиолдлын үед эсвэл ХДК-ийн хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй бөгөөд ХДК-ийн зүгээс таамаглах боломжгүй байх ба бизнесийн загварийн зорилгын хувьд тохиолдлын гэж үзэх учир тухайн санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөхгүй.

“Гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба борлуулах” бизнес загвар нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулахаас гадна тухайн хөрөнгийг борлуулснаас үүссэн мөнгөн урсгалыг цуглуулах нь мөн энэхүү бизнес загварын зорилгыг биелүүлэхэд чухал нөлөөтэйг илэрхийлнэ. Үүнд: хөрвөх чадварын удирдлага, тодорхой нэг өгөөжид хүрэхийн тулд, эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь тохируулахын тулд гэх мэт.

Үлдсэн ангилалын гол зорилго нь худалдан борлуулсанаас үүсэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор удирдаж байгаа санхүүгийн хөрөнгийн багцууд багтах бөгөөд жишээ нь өмнө нь худалдан борлуулсан төлөв байх ёстой. Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах нь энэ бизнес загварын хувьд заримдаа тохиолддог.

**Мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлбөрөөс бүрдэж буй эсэх үнэлгээ.** Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлбөрөөс (“ЗХҮТ”) бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлэлт өгөх шаардлагатай.

Мөнгөний үнэ цэнийн элемент нь хувирах магадлалтай, жишээ нь хэрэв гэрээний хүүгийн түвшин давтамжтайгаар өөрчлөгддөг боловч тэр давтамж нь өрийн хэрэгслийн суурь хүүгийн түвшний чиглэлтэй таарахгүй байдаг, жишээ нь зээлийн хүүнд банк хоорондын 3 сарын хүүг ашигладаг боловч хүү нь сар бүр өөрчлөгддөг. Өөрчилсөн мөнгөний үнэ цэнийн нөлөөг тодорхой хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ мөнгөн урсгалтай жишиг өрийн хэрэгсэлтэй харьцуулалт хийх байдлаар үнэлэх бөгөөд үүнийг тайлант хугацаа бүрт болон хэрэглүүрийн хугацааны туршид хуримтлуулан хийнэ. Үнэлгээг хамгийн боломжит бүх тохиолдолд хийсэн бөгөөд санхүүгийн зах зээлд тохиолдож болох санхүүгийн стрессийн боломжит нөхцөл байдалд ч мөн хийсэн байна. ХДК нь жишиг санхүүгийн хэрэгслүүдийн зөрүүг хэр их байгааг тодорхойлохын тулд 30%-ийн босгыг хэрэглэсэн. Мөнгөн урсгал нь жишиг үзүүлэлтээс ихээхэн зөрүүтэй байх тохиолдолд үнэлгээ хийгдсэн хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ шалгуурыг хангаж байна гэж үзэхгүй бөгөөд тухайн хэрэглүүрийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэнэ. ЗХҮТ шалгуурыг даваагүй хэрэглүүрүүд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

ХДК нь гэрээний мөнгөн урсгалын дүн болон хугацааг өөрчлөх боломжтой гэрээний нөхцлүүдийг тодорхойлж, авч үзсэн. Хэрэв аливаа зээлийг хугацаанаас нь өмнө төлөх боломжтой мөн төлбөр хийж буй дүнд үндсэн зээл болон хуримтлагдсан хүүгийн төлбөр багтдаг, түүнчлэн гэрээг хугацаанаас нь

**4. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд болон хэмжилтийн суурь (Үргэлжлэл)**

өмнө дуусгавар болговол тодорхой хэмжээний торгуул төлдөг бол ЗХҮТ шалгуур хангагдсан гэж үзнэ. Хөрөнгийн үндсэн дүн гэдэг нь анхлан хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнээс үндсэн төлбөрийн буцаан төлөх дүнг хассан дүн бөгөөд өөрөөр хэлбэл үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлсон хүүг оролцуулалгүй тооцсон дүн юм. Энэ зарчмыг үл харгалзан, стандарт нь урьдчилан төлөх нөхцөлтэй санхүүгийн хэрэгслүүдийг доорхи шалгуурыг хангасан тохиолдолд ЗХҮТ шалгуур хангасан гэж үзнэ: (1) хөрөнгийг хөнгөлөлт эсвэл урамшуулалтайгаар гаргасан (2) урьдчилгаа төлбөрийн дүн нь гэрээний эхэн төлбөрийн дүн ба хуримтлуулсан хүүгийн дүнгээс бүрддэг, мөн гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болговол тодорхой хэмжээний торгуул төлдөг мөн (2) анхлан хүлээн зөвшөөрөх үеийн урьдчилгаа төлбөрийн бодит үнэ цэнэ нь материаллаг биш байх гэх мэт.

ХДК нь стандарт дахь жишээнүүдийг харгалзан үзсэн ба гэрээнд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоос үүдэлтэй онцлог шинжүүд нь тухайн хууль тогтоомж өөрчлөгдсөн тохиолдолд цаашид хэрэгжих боломжгүй болдог (зарим улсад байдаг Bail-in хуулийн адил) бөгөөд ийм тохиолдолд мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ эсэхэд үнэлгээ хийх шаардлагагүй юм.

**Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан.** Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц санг тодорхойлох нь тооцооллын хувьд ихээхэн хэмжээний тодорхой бус байдлыг бий болгодог бөгөөд удирдлага нь чухал үнэлэмжүүдийг харгалзан үзэх шаардлагатай болдог.

Удирдлага нь хадгаламж эзэмшигч нарт олгох нөхөн төлбөрийн нөөц санг тодорхойлохын тулд тооцоолол болон таамаглалыг гаргадаг. Энэхүү тооцооллыг хийхдээ ХДК нь доорх шалгуурууд дээр үндэслэн арилжааны банк тус бүрийг үнэлсэн:

- Монголбанкны шалгуур харьцаануудыг арилжааны банкуудын хангасан байдал
- Даатгагдсан хадгаламжуудын хугацааны турш дахь дундаж дүн
- Түүхэн мэдээлэл дээр үндэслэсэн Монголын арилжааны банкуудын татан буугдсан статистик
- Монголбанкны бодлогын хүүг хамгийн тохиромжит эрсдэлгүй хүүгийн түвшин хэмээн үзэж дискаунтын түвшин болгосон
- Арилжааны банкуудын талаарх ХДК-ийн олж авсан мэдлэг

Түүнчлэн, удирдлага нь балансын дараах үйл явдал буюу тайлант хугацаа дуусгавар болсон үеэс санхүүгийн тайлангууд батлагдан гарах үе хүртэлх хугацаанд болсон үйл явдлуудыг харгалзан үзсэн (Тодруулга 23). Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц санг тодорхойлохдоо тайлант хугацааны дараа татан буугдсан банкны хадгаламж эзэмшигчдэд олгосон бодит нөхөн төлбөрийн хэмжээ болон ирээдүйд шилжүүлэх нөхөн төлбөрийн тооцооллыг тусгасан.

Бодит үр дүн нь энэхүү тооцооллоос цаг хугацаа болон үнийн дүнгийн хувьд өөрчлөгдөж болох ба үүнд арилжааны банкуудын ирээдүйн алдагдлын үр дүнд ХДК-д учирч болзошгүй алдагдлууд орно. Энэ нь нөхөн төлбөрийн нөөц сангийн дансны үнэд материаллаг хэмжээний залруулга хийхийг шаардаж болно. Бодит үр дүн нь одоогийн тооцооллоос өөр байх тохиолдолд тухайн нөхцөл байдлаас шалтгаалан арилжааны банкуудаас авах жилийн хураамжийн хэмжээг ихэсгэж багасгаж болохыг ХДК санал болгож болно. Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сангийн талаар дэлгэрэнгүйг Тодруулга 11-с харна уу.

**5. Шинэ ба өөрчлөгдсөн стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт**

**СТОУС 9, "Санхүүгийн хэрэглүүр"-ын хэрэгжилт:** ХДК нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн СТОУС 9 - "Санхүүгийн хэрэглүүр" -ыг мөрдөж эхэлсэн. ХДК нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн өмнөх оны дүнг дахин тайлагнахгүй байхаар шийдсэн бөгөөд энэхүү стандартыг хэрэгжүүлж эхэлсэн өдрөөр буюу 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийн эхний үлдэгдэлд залруулга хийхээр болсон. Үүний үр дүнд, СТОУС 7 - "Санхүүгийн хэрэглүүрийн тодруулга" -ын шинэчилсэн шаардлагуудын дагуу, зөвхөн тайлант хугацаатай холбогдолтой тодруулгуудыг тодруулсан. Зэрэгцүүлэгдэх тайлант үеийн тодруулгууд нь өмнөх тайлант үед хийсэн тодруулгуудтай ижил болно.



**Хадгаламжийн Даатгалын Корпораци**  
**Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**5. Шинэ ба өөрчлөгдсөн стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт (Үргэлжлэл)**

Дараах хүснэгтэд санхүүгийн хөрөнгүүдийг ангилал тус бүрээр нь НББОУС 39-ийн хэмжилтийн дагуу дансны үнэ болон 2018 оны 1-р сарын 1-ний өдөр СТОУС 9-ийг хэрэгжүүлсний дараах дансны дүнгүүдийн зэрэгцүүлэн харуулж байна.

Мянган төгрөгөөр	Хэмжилт		НББОУС-39 дагуу дансны үнэ (2017 оны 12 сарын 31)	СТОУС 9-ийн хэрэгжилтийн нөлөө				СТОУС-9 дагуу дансны үнэ (2018 оны 1 сарын 1)
	НББОУС 39	СТОУС 9		Дахин хэмжилт		Дахин ангилал		
				ХЗА	Бусад	Зайлшгүй	Сайн дурын	
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	3&A	ХӨ	222,889,158	-	-	-	-	222,889,158
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	3&A	ХӨ	109,270,112	-	-	-	-	109,270,112
Эрх хүлээн авагч, Засгийн газраас авах авлага	3&A	ХӨ	84,599,061	(12,386,180)	-	-	-	72,212,881
Даатгалын хураамжийн авлага	3&A	ХӨ	1,940,923	-	-	-	-	1,940,923
Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	ББХО	ААБҮЦ	85,000,000	-	-	-	-	85,000,000
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>			<b>503,699,254</b>	<b>(12,386,180)</b>				<b>491,313,074</b>

**(a) Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн бүх ангиллуудыг НББОУС 39 -ын дагуу "зээл ба авлага" хэмжилтийн ангилалаас СТОУС 9-ын дагуу "хорогдуулсан өртөг" хэмжилтийн ангилалруу хэрэгжилтийн өдөр дахин ангилсан. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдал материаллаг биш байсан

**(b) Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт**

ХДК-ийн өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт болох Төрийн банкны хувьцааг СТОУС 9-ийн шаардлагын дагуу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ ангилалд ангилсан.

СТОУС 9-н дагуу өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтыг өртгөөр хэмжих боломж байхгүй тул ХДК нь СТОУС 9-ийн өөрчлөлтийн дагуу хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн бөгөөд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгөд дахин ангилсан.

2017 оны 12 сарын 31-ний байдлаар ХДК-ийн бүх санхүүгийн өр төлбөрүүд нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдэж байса ба санхүүгийн өр төлбөрүүдийн ангилал болон хэмжилтэнд өөрчлөлт ороогүй болно.

2018 оны 1 сарын 1-ний байдлаар СТОУС 9-руу шилжилтийн хуримтлагдсан ашигт хэрхэн нөлөөлснийг доорх хүснэгтэд харуулав.

**Хадгаламжийн Даатгалын Корпорац  
Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**5. Шинэ ба өөрчлөгдсөн стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт (Үргэлжлэл)**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Оруулсан хөрөнгө</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>Нийт эзэмшигчдийн өмч</b>
<b>СТОУС 9-ийн хэрэгжилтээс өмнөх 2017 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>100,000,000</b>	<b>214,358,693</b>	<b>314,358,693</b>
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн дансны авлагуудад СТОУС 9-ийн дагуу ХЗА-ийг хүлээн зөвшөөрөлт	-	(12,386,180)	(12,386,180)
<b>2018 оны 1 сарын 1-ний байдлаар (СТОУС 9-н дагуу)</b>	<b>100,000,000</b>	<b>201,972,513</b>	<b>301,972,513</b>

2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш нэмэлт өөрчлөлт орсон дараах стандартуудыг ХДК дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд ХДК-ийн хувьд материаллаг нөлөө байхгүй байна:

- СТОУС 15 “Хэрэглэгчидтэй хийх гэрээний орлого” болон өөрчлөлтүүд
- СТОУС 2-ын өөрчлөлт, Хувьцаанд суурилсан төлбөр (2016 оны 6 дугаар сарын 20-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад мөрдөгдөнө).
- СТОУС 4 Даатгалын гэрээнд СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийг ашиглах - СТОУС 4-ийн өөрчлөлт (2016 оны 9 дүгээр сарын 12-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1- ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн түр зуурын хөнгөлөлтийг сонгосон компаниуд, эсвэл давхарлах сонголтыг хийсэн компаниудын хувьд СТОУС 9-ийг ашиглаж эхлэх үеэс мөрдөгдөнө).
- 2014-2016 оны СТОУС-ын жилүүдийн сайжруулалт - СТОУС 1 ба НББОУС 28-ын өөрчлөлт (2016 оны 12 дугаар сарын 8-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад мөрдөгдөнө).
- СТОУТХ 22 “Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнүүд болон урьдчилан анхаарал хандуулах” (2016 оны 12 дугаар сарын 8-ны өдөр гаргасан ба 2018 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад хүчин төгөлдөр)
- Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн шилжүүлэг - НББОУС 40-ийн өөрчлөлт (2016 оны 12 дугаар сарын 8-нд батлагдсан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад мөрдөгдөнө)

**6. Нягтлан бодох бүртгэлийн шинэ мэдэгдлүүд**

2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг ХДК хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

**СТОУС 16, Түрээс (2016 оны 1 дүгээр сарын 13-нд батлагдсан ба 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи өдрүүдээс эхлэн тайлант хугацаануудад хүчин төгөлдөр).** Шинэ стандартаар түрээсийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон тодруулгыг хэрхэн бэлтгэх талаар зарчмуудыг бий болгосон. Бүх түрээсийн хувьд түрээслэгч нь түрээсийн эхэнд хөрөнгийг ашиглах эрхийг гэрээ хүчин төгөлдөр болсон хугацаанаас эхлэн эзэмших ба хэрэв түрээсийн төлбөр олон удаагийн төлбөрөөр хийх бол түрээслэгч түрээслүүлэгчээс санхүүжилт авсан гэж үзнэ. НББОУС 17-ын дагуу түрээсийг үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж ангилна гэж заасан байсныг хасаж түрээсийн бүртгэлийн нэг л загварыг СТОУС 16-аар танилцуулсан. Түрээслэгч (а) 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийн түрээсийн хөрөнгийн үнэ цэнэ бага байхаас бусад тохиолдолд, түрээслүүлж буй хөрөнгийн өртөг материаллаг бус байхаас бусад бүх түрээсийн тохиолдолд холбогдох өр төлбөрийг бүртгэх ба б) орлогын тайланд түрээсийн хөрөнгийн элэгдлийг түрээсийн төлбөрийн хүүгийн зардлаас тусад нь тайлагнана. НББОУС 17-д заасан түрээслүүлэгчтэй холбоотой бүртгэлийн заалтын ихэнх хэсгийг СТОУС 16-д оруулсан. Тиймээс түрээслүүлэгч түрээсийн шинж чанараас нь хамааруулан санхүүгийн болон үйл ажиллагааны

## **Хадгаламжийн Даатгалын Корпораци** **Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

### **6. Нягтлан бодох бүртгэлийн шинэ мэдэгдлүүд (Үргэлжлэл)**

түрээсийг ангилж, ангиллын дагуу санхүүгийн тайланд өөр өөрөөр тусгадаг. ХДК-ийн хувьд санхүүгийн тайланд материаллаг хэмжээний нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

**СТОУС 17 Даатгалын гэрээнүүд (2017 оны 5 сарын 18-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2021 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө).** СТОУС 17 нь СТОУС 4-ыг орлосон бөгөөд практикт хэрэглэгдэж байгаа даатгалын гэрээний нягтлан бодох бүртгэлийг хөтөлж хэрэгжүүлэхийг компаниудад олгосон. Үүний үр дүнд ижил төрлийн даатгалын компаниудаас бусад тохиолдолд санхүүгийн гүйцэтгэлийг зэрэгцүүлэн харьцуулахад Хөрөнгө оруулагч нарт хэцүү байсан. СТОУС 17 нь Даатгагчийн эзэмшиж байгаа давхар даатгалын гэрээг хамруулсан даатгалын бүх төрлийн гэрээнүүдийг тайлбарлах нэг зарчимд суурилсан стандарт юм. Стандарт нь групп даатгалын гэрээнүүдийн хэмжигдэхүүн, хүлээн зөвшөөрөлтийг шаарддаг: (i) мөнгөн гүйлгээний гүйцэтгэлийн талаарх бэлэн байгаа бүх мэдээллүүдийг зах зээлийн мэдээлэлд нийцэхүйц байдлаар нэгтгэсэн ирээдүйн мөнгөн гүйлгээний эрсдэлд тохируулагдсан одоогийн үнэ цэнэ (гүйцэтгэлийн мөнгөн гүйлгээ): нэмэх (хэрэв энэ үнэ өр төлбөр бол) эсвэл хасах (хэрэв энэ үнэ хөрөнгө бол) (ii) гэрээний хэрэгжээгүй ашгийг харуулсан дүн (гэрээт үйлчилгээний ашиг). Даатгагч нь даатгалын гэрээний хугацаанд даатгалын бүлэг гэрээний ашгийг хүлээн зөвшөөрч, эрсдэлээс чөлөөлөгдөнө. Хэрэв бүлэг гэрээнүүд алдагдалд хүрэх эсвэл алдагдал гарвал аж ахуйн нэгж нь алдагдалыг нэн даруй хүлээн зөвшөөрөх болно. ХДК одоогийн байдлаар шинэ стандартын санхүүгийн тайлан дахь нөлөөлөлд үнэлгээ хийж байгаа.

Дараах шинэ мэдэглүүд батлагдсанаар ХДК-д ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна:

- Сөрөг төлбөртэй урьдчилсан төлбөрийн нөхцөлүүд - СТОУС 9-д орсон өөрчлөлтүүд (2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи тайланд дагаж мөрдөнө).
- Хараат компани ба хамтарсан үйлдвэр дэх урт хугацааны ашиг сонирхол - НББОУС 28-д оруулсан өөрчлөлтүүд (2017 оны 10 дугаар сарын 12-нд гарсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи тайланд дагаж мөрдөнө).
- 2015-2017 оны үед СТОУС-ын жилийн өөрчлөлтийг сайжруулах - СТОУС 3, СТОУС 11, НББОУС 12 ба НББОУС 23-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (2017 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдан гарсан ба 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи тайланд дагаж мөрдөнө).
- НББОУС 19-д гарсан өөрчлөлтүүд "Нэмэлт өөрчлөлт, хасалт хийх, төлбөр тооцоог төлөвлөх" (2018 оны 2-р сарын 7-нд батлагдан гарсан бөгөөд 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойшхи тайлант хугацаануудад дагаж мөрдөнө).
- Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээнд гарсан өөрчлөлтүүд (2018 оны 3-р сарын 29-нд батлагдан гарсан бөгөөд 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойшхи тайланд дагаж мөрдөнө).
- Бизнесийн тодорхойлолт – СТОУС 3-д орсон өөрчлөлтүүд (2018 оны 10-р сарын 22-нд батлагдан гарсан бөгөөд 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойшхи тайланд дагаж мөрдөнө).
- Материаллаг байдлын тодорхойлолт – НББОУС 1 ба НББОУС 8-д орсон өөрчлөлтүүд (2018 оны 10-р сарын 31-нд батлагдан гарсан бөгөөд 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойшхи тайланд дагаж мөрдөнө).

### **7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018 оны 12 сарын 31</b>	<b>2017 оны 12 сарын 31</b>
Касс дахь бэлэн мөнгө	9,850	11,220
Монголбанкны үнэт цаас	298,328,099	167,059,873
Банкин дахь хадгаламж	99,071,569	55,818,065
<b>Нийт</b>	<b>397,409,518</b>	<b>222,889,158</b>

2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-нээрх мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь дотоодын арилжааны банкууд дахь харилцах данс болон хугацаатай хадгаламжийн дансанд байсан.

**Хадгаламжийн Даатгалын Корпораци**  
**Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Үргэлжлэл)**

Монголбанкны үнэт цаас нь 21-ээс 28 хоног хүртэл хугацаатай, дунджаар жилийн 11 хувийн өгөөжтэй (2017: 7-оос 90 хоног хүртэл хугацаатай, дунджаар жилийн 14 хувийн өгөөжтэй) үнэт цаас орно. Бүх мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь Монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн.

2018 оны 12 дугаар сарын 31-нээрх Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцогдох санхүүгийн хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд харуулав. ХДК-ийн зээлийн эрсдэлийн ангиллын талаар Тодруулга 18-аас үзнэ үү.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Банкин дахь хадгаламж</b>	<b>Монголбанкны үнэт цаас</b>	<b>Нийт</b>
- Сайн	98,092,047	-	<b>98,092,047</b>
- Хангалттай	191,072	176,224,909	<b>176,415,981</b>
- Тусгайлан хянах	788,450	122,103,190	<b>122,891,640</b>
<b>Нийт</b>	<b>99,071,569</b>	<b>298,328,099</b>	<b>397,399,668</b>

ХДК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжих зэрэглэл Мүүдийг үнэлгээний агентлагийн үнэлгээгээр дараах байдалтай байсан:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Банкин дахь хадгаламж</b>	<b>Монголбанкны үнэт цаас</b>	<b>Нийт</b>
<i>Хугацаа хэтрэлт, үнэ цэнийн бууралтгүй:</i>			
- Саа 1 зэрэглэлтэй	55,592,985	167,059,873	<b>222,652,858</b>
- Зэрэглэлгүй	225,080		<b>225,079</b>
<b>Нийт</b>	<b>55,818,065</b>	<b>167,059,873</b>	<b>222,877,937</b>

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих зорилгоор мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь 2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар шатлал 1-д багтсан. Энэхүү үлдэгдэлд хамаарах хүлээгдэж буй зээлийн алдагдал нь материаллаг бус тул ХДК нь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд зээлийн алдагдлын сан тооцоолоогүй болно.

**8. Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт**

ХДК Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг. Засгийн газрын 4,185,546 мянган төгрөгийн (2017: 109,270,112 мянган төгрөг) дүн бүхий үнэт цаас нь купонтой ба дискаунттай гэсэн хоёр төрөлтэй. Засгийн газрын үнэт цааснууд нь 3 сараас 10 жил хүртэл хугацаатай бөгөөд жилийн дундаж өгөөж нь 11-ээс 13.5 хувь байна (2017: 3 сараас 10 жил, жилийн ашиг нь 11-ээс 17 хувь).

2018 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Засгийн газрын үнэт цаасны зээлийн эрдэлийн зэрэглэлд тулгуурласан эрсдэлийн чанар нь "онц сайн" байсан бөгөөд ХЗА-г хэмжих зорилгоор 1-р шатлалд багтсан. ХДК-ийн зээлийн эрсдэлийн чанарын ангилал, хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийн арга, дефолтын тодорхойлолт болон зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн тодорхойлолтын талаар Тодруулга 18-аас үзнэ үү.

Энэхүү үлдэгдэлд хамаарах хүлээгдэж буй зээлийн алдагдал нь материаллаг бус тул ХДК нь өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтад зээлийн алдагдлын сан тооцоолоогүй болно.

**9. Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018 оны 12 сарын 31</b>	<b>2017 оны 12 сарын 31</b>
Эрх хүлээн авагчаас авах авлага	108,736,000	105,848,942
Засгийн газраас авах авлага	7,793,998	7,793,998
Хасах нь зээлийн алдагдлын сан	(42,733,853)	(29,043,879)
<b>Нийт</b>	<b>73,796,145</b>	<b>84,599,061</b>

**9. Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага (Үргэлжлэл)**

2013 оны 7 дугаар сарын 22-нд Монголбанк Хадгаламж банкыг албадан татан буулгах шийдвэр гаргасан. Монголбанкны шийдвэрийн дагуу Хадгаламж банкыг Төрийн банктай нэгтгэсэн ба үүний үр дүнд Төрийн банкинд санхүүгийн туслалцаа шаардлагатай болсон. Банкн дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуульд заагдсан өөрийн үүргийн дагуу ХДК нь Төрийн банкинд Монголбанкнаас 10 жилийн хугацаатай жилийн 0.5 хувийн хүүтэй авсан 119,9 тэр бум төгрөгөөр санхүүгийн туслалцаа үзүүлсэн (Тодруулга 12).

Монголбанкт хийсэн зээлийн гэрээгээр ХДК нь Хадгаламж банкны зээлийн багцын авлагыг эргэн төлүүлэх зорилгоор байгуулагдсан Хадгаламж банкны эрх хүлээн авагчаас (“Эрх хүлээн авагч”) 119,9 тэрбум төгрөгийг хүлээн авах эрхтэй.

Хадгаламж банкны зээлийн багцтай холбоотой авлагуудыг цуглуулах зорилготой Засгийн газрын байгууллага байгуулагдсан ба ХДК, Монголбанк, Төрийн банк болон Эрх хүлээн авагчийн хооронд хийгдсэн хэлцлийн хүрээнд, Хадгаламж банкны зээлийн багц Төрийн банкны эзэмшилээс Эрх хүлээн авагчийн эзэмшилд шилжсэн бөгөөд үүний хариуд Төрийн банк нь ХДК-аас санхүүгийн туслалцаа авсан. Эрх хүлээн авагчид шилжсэн Хадгаламж банкны зээлийн багцын дийлэнх хэсэг нь үнэ цэнийн бууралттай буюу эргэн төлөгдөх найдваргүй зээл учир хэлцлийн эхэнд Монголбанк Эрх хүлээн авагчийн эргэн төлүүлж чадаагүй дүнгээр ХДК-д нөхөн олговор олгохоор тохирсон. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Эрх хүлээн авагч нь байгуулагдсанаасаа хойш 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд татан буугдсаны дараа Монголбанк Хадгаламж банкны зээлийн эргэн төлүүлэлтийг хариуцна.

2013-2015 онд ХДК-ийн удирдлага 119,9 тэрбум төгрөгийн санхүүгийн туслалцаа нь Эрх хүлээн авагч эсвэл Монголбанкнаас 3 жилийн дотор бүрэн эргэн төлөгдөх боломжтой бөгөөд үнэ цэнийн бууралтын нөөц байгуулах шаардлагагүй гэж үзсэн. Эрх хүлээн авагч, Монголбанкнаас авах авлага нь хүүгүй учир, ХДК уг авлагыг анх хүлээн зөвшөөрөх үед 30,722,699 мянган төгрөгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз бүртгэсэн. Ингэснээр холбогдох авлагууд нь эдгээр санхүүгийн тайлангуудад хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн бөгөөд зах зээлийн хүү болох жилийн 10.5 хувийн хүүгийн орлого хүлээн зөвшөөрөгдсөн. Анх хүлээн зөвшөөрөх үеийн гарз нь анхны эргэн төлөгдөх хугацаа болох 2016 оны 9 дүгээр сарын 30-ныг хүртэл Монголбанкнаас хүлээн авсан зээлийн холбогдох анх хүлээн зөвшөөрөх үеийн олзтой харилцан хаагдсан бөгөөд хүүгийн орлого нь хүүгийн зардалтай мөн хаагдсан. (Тодруулга 12).

2016 болон 2017 онд Монголбанк нь Эрх хүлээн авагчийг 2019 оны 12 сарын 31 хүртэл сунгах шийдвэр гаргасан бөгөөд удирдлага нь тухайн сунгасан хугацаан дээр тулгуурлан авлагын нөхөн төлөгдөх чадварыг дахин үнэлсэн. Үүний үр дүнд эдгээр авлагуудтай холбоотойгоор 2017 онд 13,203,620 мянган төгрөгийн 2016 онд онд 8,046,261 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтын нөөцийг тус тус байгуулж байсан.

2018 оны 12 сарын 31-нээр буюу эдгээр санхүүгийн тайлангуудыг батлагдан гарах үеийн байдлаар, Эрх хүлээн авагч нь дээр дурдсан авлагаас 11,164,000 мянган төгрөгийг эргүүлэн ХДК-д төлсөн.

Эрх хүлээн авагчаас авах авлагын зээлийн алдагдлын санд дахин үнэлгээ хийхдээ удирдлага нь ХДК-ийн 75%-ийг нь эзэмшдэг Төрийн банкны 2019-2020 онд хийгдэх магадлалтай хувьчлалыг харгалза үзэж энэхүү хувьчлалын дүнгээс нөхөгдөх боломжтой гэж үзэж байгаа. Энэхүү шийдвэрийг гаргахдаа удирдлага нь 2018 оны 5 сарын 23-ны Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдсэн бөгөөд дараагийн УИХ-ын чуулганаар танилцуулагдах “Төрийн өмчит компани/банкуудыг 2018-2020 онд хувьчлах” тухай УИХ-ын тогтоолын саналыг харгалзаж үзсэн. Хувьчлагдах хугацаа болон хувьцааны хүлээгдэж буй үнэтэй холбоотойгоор шинэчилсэн тооцооллоор ХДК нь 2018 оны 1 сарын 1 болон 2018 оны 12 сарын 31-ний байдлаар 12,386,180 мянган төгрөгийн болон 1,303,794 мянган төгрөгийн нэмэлт хүлээгдэж буй зээлийн алдагдлыг СТОУС 9-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн.

Банкн дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулийн дагуу болон Засгийн газрын холбогдох тушаалуудын дагуу, Монголбанк болон Сангийн яам тус бүр 50 тэрбум төгрөгийг ХДК-д анхны хөрөнгө болгон оруулах үүрэгтэй. Монголбанк өөрийн 50 тэрбум төгрөгөө 2013 онд төлсөн. Гэвч Сангийн яам 2013 онд 35,011,902 мянган төгрөг, 2014 онд 7,194,100 мянган төгрөг төлсөн. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар Сангийн яамнаас авах авлагын үлдэгдэл 7,793,998 мянган төгрөг (2017 онд 7,793,998 мянган төгрөг) Засгийн газраас авах авлагаар тайланд бүртгэсэн. Энэхүү авлага нь 2016 оноос хойш төлөгдөх эсэх нь тодорхой бус байгаа тул Засгийн газраас авлагын нийт дүн болох 7,793,998 мянган төгрөг дээр ХДК нь 2016 оноос хойш нийт дүнгээр нь эрсдэлийн сан байгуулан.

**Хадгаламжийн Даатгалын Корпораци  
Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**9. Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага (Үргэлжлэл)**

Эдгээр авлагуудын эргэн төлөгдөх талаар болон анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг тодорхойлохтой холбоотой удирдлагын үнэлэмжийн талаар Тодруулга 4-с харна уу. Засгийн газрын буцалтгүй тусламж болон холбогдох тохируулгуудын талаарх нягтлан бодох бүртгэлийг бодлогыг Тодруулга 3-с харна уу.

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эхнээс дуусгавар болох хүртэлх хугацааны турш авлагын зээлийн алдагдлын санд орсон өөрчлөлтийг тайлбарлан харуулав.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Зээлийн алдагдлын сан</b>	<b>Дансны дүн</b>
<b>Эрх хүлээн авагчаас авах авлага</b>		
<b>2018 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>(33,636,061)</b>	<b>105,848,942</b>
Шинээр үүссэн буюу худалдан авсан	(1,303,794)	-
Эргэн төлөлт		(13,000)
Анхны хүлээн зөвшөөрөлтийн гарзын хорогдуулалт		2,900,058
Тайлант хугацааны ашиг алдагдал дахь нийт зээлийн алдагдлын сангийн зардал	(1,303,794)	2,887,058
<b>2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>(34,939,855)</b>	<b>108,736,000</b>

Засгийн газраас авах авлагад 2018 оны турш өөрчлөлт ороогүй болно.

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн 2018 оны 12 сарын 31-ний байдлаарх зээлийн эрсдэлийг доор харуулав.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Шатлал 3 (Ашиглалтын хугацааны турш дахь ХЗА)</b>	<b>Нийт</b>
<b>Эрх хүлээн авагчаас авах авлага</b>		
- Дефолт	108,736,000	108,736,000
<b>Нийт дансны үнэ</b>	<b>108,736,000</b>	<b>108,736,000</b>
Зээлийн алдагдлын сан	(34,939,855)	(34,939,855)
<b>Дансны үнэ</b>	<b>73,796,145</b>	<b>73,796,145</b>
<b>Засгийн газраас авах авлага</b>		
- Дефолт	7,793,998	7,793,998
<b>Нийт дансны үнэ</b>	<b>7,793,998</b>	<b>7,793,998</b>
Зээлийн алдагдлын сан	(7,793,998)	(7,793,998)
<b>Дансны үнэ</b>	<b>-</b>	<b>-</b>

**Хадгаламжийн Даатгалын Корпораци**  
**Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**9. Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага (Үргэлжлэл)**

2017 оны 12 сарын 31-ний байдлаарх авлагуудын зээлийн эрсдэлийн чанарыг доор харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Эрх хүлээн авагчаас авах авлага</b>	<b>Засгийн газраас авах авлага</b>	<b>Нийт</b>
Хугацаа хэтэрсэн, үнэ цэнийн бууралтгүй	105,848,942	-	<b>105,848,942</b>
Үнэ цэнийн бууралттай	-	7,793,998	<b>7,793,998</b>
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(21,249,881)	(7,793,998)	<b>(29,043,879)</b>
<b>Нийт</b>	<b>84,599,061</b>	-	<b>84,599,061</b>

2017 оны турш дахь авлагын үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөн:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Эрх хүлээн авагчаас авах авлага</b>	<b>Засгийн газраас авах авлага</b>	<b>Нийт</b>
<b>2017 оны 1 сарын 1-ний үнэ цэнийн бууралтын сан</b>	8,046,261	7,793,998	<b>15,840,259</b>
Үнэ цэнийн бууралтын сангийн зардал	13,203,620	-	<b>13,203,620</b>
<b>2017 оны 12 сарын 31-ний үнэ цэнийн бууралтын сан</b>	<b>21,249,881</b>	<b>7,793,998</b>	<b>29,043,879</b>

Эрх хүлээн авагч, Засгийн газраас авах авлагын талаар Холбоотой талуудын мэдээллийг Тодруулга 22-оос үзнэ үү. Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлагуудын 2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-нээрх бодит үнэ цэнийг Тодруулга 21-оос үзнэ үү.

**10. Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт**

Засгийн газар, Монголбанктэй тохиролцсоны дагуу ХДК нь 2013 онд Төрийн банкны 85,000 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг 1 сая төгрөгийн нэрлэсэн үнээр худалдан авч 85,000,000 мянган төгрөгийн санхүүгийн туслалцаа үзүүлсэн. Уг худалдан авалт нь Монголбанкнаас хүүгүй авсан зээлээр санхүүжигдсэн (Тодруулга 12) ба ХДК нь 2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар Төрийн банкны 75 хувийг эзэмшиж байсан. Гэвч гэрээний нөхцлийн дагуу ХДК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын саналын эрх зэрэг тодорхой эрхээ Сангийн яаманд итгэмжлэн шилжүүлсэн.

ХДК нь Төрийн банкны 75 хувийг эзэмшдэг учир ХДК-ийн удирдлага нь Төрийн банк нь ХДК-ийн охин компани, хараат компани эсвэл өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтын аль болох талаар авч үзсэн бөгөөд ХДК нь Төрийн банкинд хяналт болон нөлөө үзүүлдэггүй гэж үзсэн. ХДК-ийн удирдлагын шийдвэрийн талаар дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс үзнэ үү.

Төрийн Банк болон бусад Монголын банкуудын хувьцаа нь нээлттэйгээр хөрөнгийн бирж дээр арилжаалагддаггүй нь Төрийн Банк дахь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлох найдвартай мэдээлэл байхгүйд хүргэсэн тул удирдлага нь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлохдоо цэвэр хөрөнгө дээр суурилсан аргыг ашигласан. Тус үнэлгээнд Төрийн банкны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайлангууд болон банктэй холбоотой бусад бүх боломжит мэдээллүүд мөн Монголын банкны секторын нөхцөл байдал зэрэг хүчин зүйлүүдийг ашигласан. Үүний үр дүнд удирдлага нь бодит үнэ цэнийн тохируулга хийх шаардлагагүй гэж үзсэн. Удирдлагын үнэлэмжийн талаар илүү дэлгэрэнгүйг Тодруулга 4-с харна уу.

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээнүүдийн талаар мэдээллийг энэхүү санхүүгийн тайлангийн Тодруулга 22-с харна уу.

**11. Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан**

2018 оны 2 сарын 8-нд батлагдсан Хадгаламжийн Даатгалын Корпорацийн шинэчилсэн хуулийн дагуу ХДК-ийн гол үүрэг хариуцлагын нэг нь шаардлагатай тохиолдолд арилжааны банкуудад санхүүгийн туслалцаа үзүүлж байх тухай заасан байдаг. Хэрэв хуульд заасан үүргүүдийг биелүүлэх хангалттай нөөц байхгүй бол Монголбанк болон Засгийн газар нь ХДК-д нэмэлт санхүүгийн туслалцаа үзүүлэх боломжтой.



**Хадгаламжийн Даатгалын Корпорац  
Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**11. Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан (Үргэлжлэл)**

2018 оны 1 сарын 18-нд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хуулийн дагуу, Монголбанкны дүрэм журмыг зөрчсөн, эсвэл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн, эсвэл банкны лицензийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдол арилжааны банкуудад илэрвэл Монголбанк нь ХДК-д нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

2018 оны 12 сарын 31-нээрх хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц санг тооцоолохдоо удирдлага нь 2019 оны 4 сарын 8-ны Монголбанкны Капитал Банк ХХК-г албадан татан буулгах тухай #А-96 тоот тушаалыг анхаарч үзэн тохируулга хийх шаардлагатай үйл явдал хэмээн үзэж тайланд тусгасан.

Түүнчлэн, удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангууд батлагдан гарах өдрөөрх Активын чанарын үнэлгээний үр дүнд бий болсон банкны салбар дахь бүх боломжит мэдээллүүд дээр үндэслэн хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн магадлал нэмэгдсэн тухай авч үзсэн бөгөөд 2018 оны 12 сарын 31-ний байдлаар нөөц байгуулах шаардлагатай гэж үзсэн. Үүний үр дүнд, ХДК нь 2018 онд 51,243,353 мянган төгрөгийн хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн санг байгуулсан. Холбогдох удирдлагын үнэлэмж болон тооцооллын талаар Тодруулга 4-с харна уу.

**12. Монголбанкнаас авсан зээл**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018 оны 12 сарын 31</b>	<b>2017 оны 12 сарын 31</b>
Монголбанкнаас авсан зээл	193,744,933	190,808,477
<b>Нийт зээл</b>	<b>193,744,933</b>	<b>190,808,477</b>

2018 оны 12 сарын 31-ний байдлаарх Монголбанкнаас авсан зээл:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Мөнгөн тэмдэгт</b>	<b>Жилийн хүү</b>	<b>Нэрлэсэн үнэ</b>
Монголбанкнаас авсан зээл (I)	Төгрөг	0.5%	108,736,000
Монголбанкнаас авсан зээл (II)	Төгрөг	-	85,000,000

Эдгээр зээлүүд нь ХДК Монголын зах зээл дээр бусад зээлдэгчдээс авч болох хүүгийн түвшнээс бага хүүтэйгээр авсан зээлүүд юм. ХДК хүлээн авсан аль ч зээлээ Төрийн банкинд санхүүгийн туслалцаа үзүүлэх зорилгоор ашиглах үүрэгтэй.

**Монголбанкнаас авсан зээл (I)**

Анхлан олгосон 119,9 тэрбум төгрөгийн зээлийг Төрийн банкны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, дийлэнх нь чанаргүй зээлээс бүрдэх Хадгаламж банкны зээлийн багцыг Төрийн банкны санхүүгийн тайлангаас салгах зорилгоор олгосон. 2013 оны 9 дүгээс сард хийгдсэн тус хэлцлийн үр дүнд ХДК нь Эрх хүлээн авагчаас авах авлага хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 9). Зээлийн гэрээний хугацаа 10 жил боловч хэлцлийн эхнээс 3 жилийн дотор төлбөр тооцоо дуусахаар хүлээгдэж байсан.

**Монголбанкнаас авсан зээл (II)**

85 тэрбум төгрөгийн зээл нь Төрийн банкны нийт хувьцааны 75 хувийг худалдан авахад зориулагдсан бөгөөд тус хэлцлийн үр дүнд ХДК нь НББОУС 39-ийн дагуу борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт, СТОУС 9-ийн дагуу ашиг алдагдлаарх боди үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэрэглүүр хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 10). Уг зээлийн хугацаа 1 жил байсан бөгөөд гэрээний талууд зээл нь Төрийн банкны хувьчлалаас орж ирэх орлогоор эргэн төлөгдөнө гэж тохирсон. Зээл нь Төрийн банкны хувьчлал хойшлогдсоноос шалтгаалан энэхүү санхүүгийн тайланг баталгаажуулах өдрийн байдлаар

**12. Монголбанкнаас авсан зээл (Үргэлжлэл)**

эргэн төлөгдөөгүй болно. Хувьчлал нь ХДК-ийн удирдлагаас хамаарахгүй учир ХДК нь Монголбанкинд зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрэлтээс шалтгаалж алданги эсвэл бусад нөхөн төлбөр төлөхгүй.

Удирдлага дээрх зээлүүд НББОУС 20-ын дагуу Засгийн газрын буцалтгүй тусламж гэсэн тодорхойлолтонд нийцэх эсэхийг авч үзсэн. Засгийн газрын буцалтгүй тусламжийн тодорхойлолтонд Засгийн газраас тухайн байгууллагын үйл ажиллагаанд тодорхой нөхцөлтэйгөөр олгосон санхүүжилт багтдаг. Хэдий тийм боловч Засгийн газар өөрөө хувь эзэмшдэг ХДК-ийн үйл ажиллагаан дахь Засгийн газрын оролцоо болон ХДК-ийн хэвийн өдөр тутмын ажил гүйлгээнээс ялгах боломжгүй бол Засгийн газрын туслалцаа нь үүнд багтахгүй. Удирдлага дээрх хоёр буцалтгүй зээл нь тодорхой нөхцөлтэйгөөр олгогдсон учир НББОУС 20-д хамаарна гэж үзсэн.

Удирдлага нь зээл хүлээн авах үеийн Монголбанкны бодлогын хүү болох 10.5% нь зах зээлийн хүүгийн түвшний хамгийн боломжит харьцуулал гэж үзсэний үндсэн эдгээр зээлүүдийг хүлээн зөвшөөрөх үедээ анхлан хүлээн зөвшөөрөлтийн олзыг бүртгэсэн.

Тодруулга 4-т толилуулснаар 119,9 тэрбум төгрөгийн анх хүлээн зөвшөөрөх үеийн олз нь 30,722,699 мянган төгрөг байсан ба Эрх хүлээн авагчаас авах авлагын анх хүлээн зөвшөөрөх үеийн гарзтай ойролцоо байсан. Иймээс холбогдох хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз гарзыг хооронд нь хаасан.

ХДК нь Монголбанкинд (жилийн 0.5 хувийн хүүгээр тооцон) төлсөн хүүгийн дүнг эдгээр санхүүгийн тайлангуудад хүүгийн зардлаар бүртгэсэн. Зах зээлийн хүүгээр тооцогдсон нэмэлт хүүгийн зардал нь 2018 оны 12 дугаар сарын 31 хүртэл авлагад зах зээлийн хүүгээр тооцогдох хүүгийн орлоготой ойролцоо байсан тул хоорондоо хаагдсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 14-өөс үзнэ үү. Засгийн газрын буцалтгүй зээлийн талаарх нягтлан бодо бүртгэлийн бодлого болон удирдлагын үнэлэмжийн талаар Тодруулга 3, Тодруулга 4-өөс үзнэ үү.

Тодруулга 4-т толилуулснаар 85 тэрбум төгрөгийн зээлийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн олз нь 10,328,810 мянган төгрөг байсан бөгөөд хэлцэл хийгдсэн өдөр (ө.х Монголбанкнаас зээл хүлээн авсан өдөр) хойшлогдсон буцалтгүй тусламжийн орлогоор бүртгэгдсэн ба үүний дараа буюу 2013 болон 2014 оны санхүүгийн тайландаа тусламжийн орлогоор хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 4 -т толилуулснаар, буцалтгүй тусламжийн орлого нь хүүгийн зардалтай ойролцоо дүнтэй байсан тул хоорондоо хаагдсан. Хүүгийн зардлын талаар дэлгэрэнгүйг Тодруулга 14-өөс үзнэ үү. Засгийн газрын буцалтгүй тусламж, холбогдох удирдлагын үнэлэмжийн талаар Тодруулга 3, Тодруулга 4-өөс үзнэ үү. Монголбанкнаас авсан зээлүүдийн 2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаарх бодит үнэ цэнийн талаар мэдээллийг Тодруулга 21-с харна уу.

**13. Хүүгийн орлого**

Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулийн дагуу ХДК нь даатгалын шимтгэлээс орсон орлогоороо Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаасуудад хөрөнгө оруулалт хийх боломжтой.

Засгийн газрын үнэт цааснаас (үүнд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд ангилагдсан хэсгийг оролцуулан) олсон орлогын хураангуйг доорх хүснэгтэд харуулав (Тодруулга 7):

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018</b>	<b>2017</b>
Монголбанкны үнэт цаасны хүүгийн орлого	26,039,440	14,397,811
Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлого	3,552,196	24,277,511
<b>Нийт хүүгийн орлого</b>	<b>29,591,636</b>	<b>38,675,322</b>

ХДК нь Монголбанк болон Засгийн газраас гаргасан 1 долоо хоногоос 10 жилийн хугацаатай үнэт цаасыг худалдан авдаг. 2018 онд нэмэлтээр Засгийн газрын үнэт цаас худалдаж аваагүй. Монголбанкны үнэт цааснууд нь бүгд 3 сараас доош хугацаатай бөгөөд энэхүү санхүүгийн тайланд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөр ангилагдсан.

**14. Хүүгийн зардал**

592,898 мянган төгрөгийн (2017 онд 555,746 мянган төгрөг) хүүгийн зардал нь бүгд Монголбанкнаас авсан 119,9 тэрбум төгрөгийн, жилийн 0.5 хувийн буюу зах зээлийн хүүгийн түвшнээс бага нэрлэсэн хүүтэй (зээл олгох үеийн зах зээлийн хүү жилийн 10.5%) зээлийн хүүгийн зардал юм (Тодруулга 4). Зээл нь Засгийн газрын буцалтгүй тусламж гэж ангилагдах учир, ХДК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу (Тодруулга 3) зах зээлийн хүү болон нэрлэсэн хүүгийн зардлын зөрүү болох нэмэлт хүүгийн зардлууд нь 2018 оны буцалтгүй тусламжийн орлоготой хаагдах бөгөөд хүүгийн зардалд бүртгэгдээгүй. Буцалтгүй тусламжийн орлогод хаагдах холбогдох хүүгийн зардлууд нь 2018 оны турш 2,900,056 мянган төгрөг (2017 онд 7,257,379 мянган төгрөг) байсан. Тодруулга 4, 12-г үзнэ үү.

СТОУС-ын дагуу Монголбанкнаас авсан 85 тэрбум төгрөгийн зээлд дуусах хугацаа нь 2 жил байсны улмаас 2018 болон 2017 онуудад хүүгийн зардал хүлээн зөвшөөрөөгүй (Тодруулга 12).

**15. Даатгалын хураамжийн орлого**

ХДК нь 2018 онд арилжааны 14 банкнаас нийт 42,945,923 (2017 онд 36,085,731 мянган төгрөг, 14 банк) мянган төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсон бөгөөд эдгээр хураамжийн орлогуудыг улирлаар нь цуглуулан авч төлбөрийг сар бүрийн сүүлийн өдөр төлөх нөхцөлтэй байдаг. Даатгалын хураамжийн орлого нь тухайн банкны хадгаламжийн дундаж үлдэгдлийг ХДК-ийн Үндэсний Хорооноос тодорхойлсон хувь хэмжээгээр үржүүлж гаргадаг. 2018 оны хураамжийн хувь хэмжээ нь улирлын 0.0625% буюу 2017 оныхоос өөрчлөгдөөгүй байна. Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулийн дагуу энэ хувь хэмжээ нь жилийн 0.5%-аас хэтрэхгүй байх ёстой. Даатгалын хураамжийн өсөлт нь банкуудын нийт хадгаламжийн өсөлттэй холбоотой юм. Хэрэв ХДК-ийн сангийн үлдэгдэл бүх банкны хадгаламжийн үлдэгдлийн 10%-аас хэтэрсэн бол улирлын хураамжийг цуглуулахгүй бөгөөд ХДК-ийн тооцооллоор 2020 он хүртэл энэхүү үйл явдал гарахгүй бөгөөд хураамжаа цуглуулсаар байх болно гэж үзсэн.

**16. Ерөнхий болон үйл ажиллагааны зардал**

2018 болон 2017 оны ерөнхий болон үйл ажиллагааны зардлыг доорхи хүснэгтэд харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018</b>	<b>2017</b>
Цалингийн зардал	1,251,259	1,166,482
Түрээсийн зардал	287,956	288,938
Хорогдлын зардал	231,075	170,908
Нийгмийн даатгалын зардал	229,565	155,080
Сургалтын зардал	166,471	122,800
Албан томилолтын зардал	143,423	116,526
Элэгдлийн зардал	96,474	93,182
Зар сурталчилгааны зардал	63,680	63,985
Оффисын үйлчилгээний зардал	34,182	40,651
Шуудангийн зардал	28,760	22,298
Түлш шатахууны зардал	28,269	15,302
Бусад	291,131	179,290
<b>Нийт</b>	<b>2,852,245</b>	<b>2,435,442</b>

**17. Оруулсан хөрөнгө**

Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулийн дагуу болон Засгийн газрын холбогдох тушаалуудын дагуу, Монголбанк болон Сангийн яам тус бүр 50 тэрбум төгрөгийг ХДК-д анхны хөрөнгө болгон оруулах үүрэгтэй. Монголбанк 50 тэрбум төгрөгийн 2013 онд оруулсан ба Сангийн яам нь 2013 онд 35,011,902 мянган төгрөг, 2014 онд 7,194,100 мянган төгрөгийг тус тус хөрөнгө оруулсан. Засгийн газраас авах авлагын талаар дэлгэрэнгүйг Тодруулга 9-с харна уу.

**18. Санхүүгийн эрсдэлийн удирдлага**

ХДК-ийн эрсдэлийн удирдлагын функц нь санхүү, үйл ажиллагаа болон хуультай холбогдох бүх эрсдэлийн хүрээг хамааруулан авч үздэг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл (үүнд валют, хүүгийн болон бусад үнийн эрсдэл орно), зээлийн эрсдэл болон хөрвөх чадварын эрсдэлийг хамруулан авч үздэг. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүлээж болох эрсдэлийн хязгаарыг тогтоож, улмаар бодит эрсдэлийг тухайн тогтоосон хязгаарт барих явдал юм.

ХДК нь Банкин дахь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хууль болон Үндэсний Хорооны тогтоосон хэм хэмжээнд захирагдан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ямар нэгэн арилжааны шинжтэй үйл ажиллагаанд оролцдоггүй. ХДК-д санхүүгийн эрсдэлийн удирдлагын талаар батлагдсан дүрэм журам байхгүй боловч эдгээр эрсдэлүүдийг хэрхэн удирддаг арга барилыг доор толилуулав.

**Зээлийн эрсдэл.** Санхүүгийн хөрөнгийн хувьд нөгөө тал үүргээ биелүүлээгүйн улмаас ХДК-д санхүүгийн алдагдал учрах эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Энэхүү эрсдэл нь ХДК-ийн зээлийн борлуулалт эсвэл санхүүгийн хөрөнгийг нэмэгдүүлэх бусад ажил гүйлгээнээс үүсдэг. ХДК-ийн зээлийн эрсдэлд хамгийн их өртдөг санхүүгийн хөрөнгүүдийг ангиллаар нь дансны үнэд нь тусган санхүүгийн байдлын тайланд доорх байдлаар толилуулсан.

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2018 оны 12 сарын 31</b>	<b>2017 оны 12 сарын 31</b>
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	397,409,518	222,889,158
Өрийн хэрэглүүрээр хөрөнгө оруулалт	4,185,546	109,270,112
Эрх хүлээн авагч, Засгийн газраас авах авлага	73,796,145	84,599,061
Даатгалын хураамжийн авлага	1,920,635	1,940,923
<b>Зээлийн эрсдэлийн хамгийн их дүн</b>	<b>477,311,844</b>	<b>418,699,254</b>

**Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем.** Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэгслийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд ХДК нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагуудын (Мүүдийс, Стандарт энд Пүүрс, Фитч) гаргасан эсдэлийн үнэлгээг ашигладаг. Хөндлөнгийн зээлийн үнэлгээг дотооддоо бий болгосон дефолт болох магадлалын тодорхойлогдсон үнэлгээтэй уялдуулан доорх байдлаар тооцоолдог:

<b>Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр</b>	<b>Хөндлөнгийн үнэлгээний агентлагийн өгсөн тохирох үнэлгээ (Мүүдийс)</b>	<b>Дефолт магадлал</b>
Онц сайн	AAA to A3	0% -0,07%
Сайн	Baa1 to B3	0,14% - 5,55%
Хангалттай	Сaa1 to Сaa3	5,24% - 21,74%
Тусгайлан хянах	Ca to C	4,01% - 34,65%
Дефолт	Default	100%

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- *Онц сайн* – зээлийн чанар маш сайн, зээлийн эрсдэл бага;
- *Сайн* – зээлийн чанар сайн, зээлийн эрсдэл дунд зэрэг;
- *Хангалттай* – зээлийн чанар дунд зэрэг, зээлийн эрсдэл хангалттай;
- *Тусгайлан хянах* – ойроос хянах шаардлагатай, сайжруулах удирдлагыг баримтлах хэрэгслүүд;
- *Дефолт* – дефолт болсон хэрэгсэл.

Харилцагч байгууллагуудыг үнэлэхдээ хөндөнгийн олон улсын үнэлгээний агентлагууд болох Мүүдийс, Стандарт энд Пүүрс, Фитч-с гаргасан үнэлгээг ашигласан. Эдгээр үнэлгээнүүд нь олон нийтэд нээлттэй байдаг. Эдгээр үнэлгээнүүд болон дефолт болох магадлалын харгалзах хүрээ нь Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, Авалага болон Засгийн газрын үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгүүдэд хэрэглэгдсэн.

Үнэлгээ хийгдээгүй харилцагч байгууллагын хувьд ХДК нь дотоодын зээлийн үнэлгээний системийг ашиглахын оронд өөрийн мэргэжилтнүүдийн дүгнэлтийг зээлийн эрсдэлийн үнэлгээндээ ашигладаг.

## **18. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

**Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХЗА)-ын хэмжилт.** Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь ирээдүйн бэлэн мөнгөний дутагдалын одоогийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жигнэсэн тооцоолол (өгөгдсөн хугацаанд дефолт болох эрсдэлээр жигнэсэн зээлийн алдагдлын жигнэсэн дундаж) юм. ХЗА хэмжилт нь олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлогддог. ХЗА-ын хэмжилтийг ХДК-ийн хэрэглэдэг дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэслэн тогтооно: Үүнд дефолт болох магадлал, Дефолт болсон үеийн дүн, Дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ (дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ) болон дискаунтчилсан үр дүн орно.

Дефолт болсон үеийн дүн гэдэг нь тайлант хугацааны дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг авч үзэн зээлдэгч ирээдүйд дефолт болох үед хэдий хэмжээний өртэй байх таамаглал юм. Дефолт болох магадлал гэдэг нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд дефолт болох магадлалыг тооцоолдог. Дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ гэдэг нь дефолтоос болж үүссэн алдагдлын тооцоолол болно. Энэ нь төлөх ёстой гэрээний мөнгөн урсгал болон зээлдэгчийн барьцаа хөрөнгөөс гарах мөнгийг оролцуулан хүлээж буй мөнгөн дүн хоёрын зөрүүнд үндэслэх бөгөөд ихэвчлэн дефолт болсон үеийн дүнгийн хувиар илэрхийлдэг. ХЗА нь тайлант хугацааны эцэст дискаунтчилагдан одоогийн үнэ цэнээр бүртгэгддэг. Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшингээр дискаунтын хувь тодорхойлогдоно.

Хүлээгдэж буй алдагдлыг санхүүгийн хэрэгслийн ашиглалтын хугацааны турш загварчилсан ба ашиглалтын хугацаа гэдэг нь өрийн хэрэгслийн гэрээний дагуух үлдсэн хугацаа (хэрэв төлөлт хийгдсэн бол түүнийг тохируулсан хугацаа) юм.

Удирдлага нь санхүүгийн хэрэгслийн үлдсэн ашиглалтын хугацааны турш гарч болох боломжит бүх дефолт үйл явдлуудаас үүссэн алдагдлыг ашиглалтын хугацааны ХЗА гэж загварчилсан. 12 сарын ХЗА гэдэг нь ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдлын тайлант жил дуусгавар болсноос хойш 12 сарын дотор тохиолдож болох дефолт үйл явдлуудыг хамаарах ба хэрэв санхүүгийн хэрэгсэл нь нэг жилээс богино хугацаатай бол үлдсэн ашиглалтын хугацааг хэлнэ.

Энэхүү санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагын тооцоолсон ХЗА нь захиргааны зорилгоор голдуу ашиглагддаг циклийн туршид тооцоолох тооцооллоос илүүтэйгээр тухайн цаг хугацааны тооцоолол байна. Тооцоолол нь *ирээдүйг харсан мэдээллийг* авч үздэг бөгөөд үүнд ХЗА нь зээлийн эрсдэлд нөлөө үзүүлэх макро эдийн засгийн гол хувьсагчуудын магадлалаар жигнэсэн дүнд тусгагддаг.

ХЗА загварчлал нь анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан санхүүгийн хөрөнгө дээр дараах зүйлсээр ялгаатай: (а) гэрээний мөнгөн урсгалд суурилхаас илүүтэйгээр хөрөнгийн анх хүлээн зөвшөөрсөн үед төлөгдөж болох мөнгөн урсгалд суурилж нийт дансны үнэ болон хямдруулалтын хүүгээ тооцолно, (b) ХЗА нь үргэлж ХЗА-ын ашиглалтын хугацааны турш байна. Анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан санхүүгийн хөрөнгө гэдэг нь анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгүүд, жишээ нь: бизнесийн нэгдэлийн үед хүлээн авсан үнэ цэнэ буурсан зээлүүд.

Дефолт болох магадлалыг хэмжих зорилгоор ХДК нь доорхоос нэг буюу хэд хэдэн шалгуурыг хангасан нөхцөл байдлыг дефолт гэж тодорхойлдог:

- Гэрээний төлбөрийг 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн;
- Төлбөр төлөхгүй байх магадлалын доорх шалгууруудыг хангасан:
  - o Гэрээний үүрэгт хүү эсвэл үндсэн төлөлтийг төлөөгүй эсвэл хугацаа хэтэрсэн
  - o Дампуурлаа зарласан эсвэл хуулийн эрх хүлээн авсанаас үүдэн гэрээгээр хүлээсэн өр төлбөрийн эргэн төлөлтийг төлөхгүй байх эсвэл хугацаа хэтрэх магадлалтай болсон
  - o Валютын ханшийн хямрал
  - o Гэрээний эргэн төлөлтийн нөхцөлд өөрчлөлт орсон эсвэл эрх бүхий байгууллагаас гэрээ байгуулсанаас үүдэн санхүүгийн үүрэг хариуцлагыг нь бууруулсан, үүнд гэрээний валютыг хүчээр өөрчилсөн (зээлдэгч эсвэл зээлдэгчийн эрх бүхий байгууллагаас) эсвэл анхны амлалтын зарим зүйлсийг хүчээр өөрчилсөн, жишээ нь индексац, дуусах хугацаа гэх мэт.

Дефолт болох шалгуур үзүүлэлтүүдийг дараалсан 6 сарын турш хангаагүй үед хэрэгслийг дефолт гэж үзэхээ болино.

ХДК-д цөөн тооны харилцагч талуудтай тул анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн

**18. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

мэдэгдэхүйц өсөлт (SICR) байгаа эсэх үнэлгээг тухайн санхүүгийн хэрэгсэл тус бүрийн хувьд хийнэ. Зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг тодорхойлоход ашиглагдах шалгуур үзүүлэлтүүдийг ХДК-ийн удирдлагын зүгээс зохих хугацаанд байнга хянаж үздэг. Санхүүгийн хөрөнгө 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн бол анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн нөлөө өөрчлөлт байсан гэсэн таамаглалыг няцаагаагүй болно.

ХДК нь хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгөд бага зээлийн эрсдэлийн үнэлгээг ашиглахгүй байхаар шийдсэн. Тиймээс хөрөнгө оруулалтын зэрэгтэй хөрөнгийг зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг үнэлнэ.

ХДК нь санхүүгийн хэрэгслийг доорх тоон болон чанарын үзүүлэлтүүдэдээс нэг буюу хэд хэдэн шалгууруудыг хангасан тохиолдолд SICR байна гэж үзнэ.

- 30 болон 90 хоногоор хугацаа хэтэрсэн
- Хөндлөнгийн үнэлгээнд суурилсан тайлант хугацааны дефолт болох магадлалын коэффициентийг хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох магадлал коэффициенттэй харьцуулна. Хөндлөнгийн үнэлгээ 2 зэргээр буурахад зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт гэж үзнэ.
- Тухайн бизнесийн үйл ажиллагаа явуулж буй орчинд бизнес, санхүү, эдийн засгийн нөхцөлд мэдэгдэхүйц сөрөг өөрчлөлт гарсан
- Аж, ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн үзүүлэлтэд бодитоор эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц сөрөг өөрчлөлт гарсан
- Худалдааны өглөг/зээлээ оройтож төлөх гэх мэт мөнгөн урсгал/хөрвөх чадварын асуудалд орсон байж болох эхэн үеийн шинж тэмдгүүд илэрсэн
- Монголбанкнаас санхүүгийн хүндрэлийн улмаас албан ёсны мэдэгдэл хүлээн авах
- Хэрэв дефолт шинж тэмдэг байгаа бол зээлдэгчийг 3-р шатлалд хуваарилна

Энэхүү санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ХЗА-ын түвшин нь зээлдэгчийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өссөн байгаа эсэхээс хамаарна. Энэ нь ХЗА-ын хэмжилтийн 3-шатлалт загвар болно. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр зээлийн үнэ цэнэ буураагүй мөн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гараагүй санхүүгийн хэрэглүүрийг 12 сарын ХЗА (1-р шатлал)-д үндэслэн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулна. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш SICR гарсан бол санхүүгийн хэрэглүүрийг 2-р шатлалруу шилжүүлэх боловч зээлийн үнэ цэнэ хараахан буураагүй бөгөөд эрсдэлийн санг ХЗА-ын ашиглалтын хугацаанд үндэслэн байгуулна. Хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнэ буурсан бол 3-р шатлалд шилжүүлэх бөгөөд эрсдэлийн санг ХЗА-ын ашиглалтын хугацаанд үндэслэн байгуулна. Хөрөнгө 3-р шатлалд байснаар нийт дансны үнэд суурилсан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхөө зогсоох бөгөөд хүүгийн орлогоо тооцоолохдоо ХЗА-г хассан дансны үнэд хөрөнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцоолно.

Хэрэв SICR шалгуур хангагдахаа больсон гэдэг нь нотлогдсон бол хэрэглүүрийг 1-р шатлалруу буцааж шилжүүлнэ. Чанарын үзүүлэлтээр үнийн дүнг 2-р шатлалруу шилжүүлсэн бол ХДК нь энэ үзүүлэлт хэвээр байгаа эсвэл өөрчлөгдсөн эсэхэд хяналт тавина.

Анхнаас нь үнэ цэнийн бууралттай байх үед нь худалдан авсан эсвэл үнэ цэнийн бууралттай шинээр гаргасан санхүүгийн хөрөнгүүдийн ХЗА-г нийт хугацааных нь туршид хэмжинэ. Иймд ХДК нь зөвхөн нийт хугацааны турш дахь ХЗА-д гарсан хуримтлагдсан өөрчлөлтийг хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө тус бүрийн хувьд хийгдэх ХЗА-ын үнэлгээг олон төрлийн боломжит үр дагаварууд дээрх зээлийн алдагдлыг үр дагавар бүрийн магадлалынх нь эсрэг хэмжиж гүйцэтгэдэг. ХДК нь үнэлгээ хийх хөрөнгө бүрийн хувьд хамгийн багадаа 2 боломжит үр дагаварыг тодорхойлж, түүний аль нэг хувилбарын магадлал маш бага байсан ч эрсдэл гарсан байдаг. Хөрөнгө тус бүрт хийх үнэлгээ нь голцуу туршлагатай ажилтнуудын мэргэжлийн дүгнэлт дээр үндэслэсэн байдаг. Мэргэжилтнүүдийн дүгнэлтийг тооцооцол болон бодит алдагдлын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянаж байдаг.

ХЗА нь зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүд болох дефолт болсон үеийн дүн, дефолт болох магадлал ба дефолт болсон үеийн алдагдлын хувь хэмжээний үржвэрүүдийн нийлбэрийг үр ашигт хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан дүн юм. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгүүд хамтдаа үржигдэж, оршин тогтнох магадлалыг тохируулна (жишээ нь зээл нь өмнөх саруудад төлөгдөөгүй эсвэл дефолт болсон). Энэ нь ирээдүйн ХЗА-г тооцоолж дараа нь тайлангийн огноо руу буцаан дискаунтчилан

**18. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

нэгтгэх юм. ХЗА-н тооцоололд ашигласан дискаунтын түвшин нь анхны үр ашигт хүүний түвшин буюу түүнтэй ойролцоо дүн байна.

**Зээлийн эрсдэлийн параметруудийг тооцоолох гол зарчмууд.** Дефолт болсон үеийн дүнг бүтээгдэхүүний төрлөөс хамааран өөр өөр байдаг хүлээгдэж буй төлбөрийн байдалд үндэслэн тодорхойлно. Дефолт болсон үеийн дүнг 12 сар эсвэл нийт хугацааны туршид бүтээгдэхүүнийг хорогдуулан харилцагч байгууллагын төлөх ёстой гэрээний эргэн төлөлтүүдэд үндэслэнэ. Зээлдэгчийн илүү төлөлтөөр залруулга хийнэ. Хугацаанаас нь өмнө эргэн төлөлт хийх болон дахин санхүүжилт хийх эсэх талаар таамаглалуудыг мөн тооцоололд оруулдаг. Эдгээр таамаглал нь бүтээгдэхүүний төрөл, одоогийн зээлийн хязгаарыг ашигласан байдал болон бусад зээлдэгчийн зан байдлын онцлогоос хамааран олон янз байна.

ХЗА-г тооцоолоход 2 төрлийн дефолт болох магадлалыг ашиглана: 12 сарын болон ашиглалтын хугацааны дефолт болох магадлал. 12 сарын дефолт болох магадлалын үнэлгээг хийхэд хөндлөнгийн олон улсын байгууллагаас гаргасан хамгийн сүүлийн үеийн ашиглах боломжтой дефолтын мэдээллийг боломжтой бол ирээдүйг харсан мэдээлэлд тохируулж ашиглана. Ашиглалтын хугацааны дефолт болох магадлал нь санхүүгийн хэрэглүүрийн үлдсэн ашиглалтын хугацаанд тохиолдох дефолтын магадлалыг тооцоолох ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны турш дахь 12 сарын дефолт болох магадлалын нийлбэр юм.

Дефолт болсон үеийн алдагдлын хэмжээ нь дефолт болсон үеийн дүнд ХДК-ийн хүлээх алдагдлын түвшинг илтгэнэ. ХДК нь түүхэн мэдээллийн хязгаарлагдмал байдлын улмаас дефолт болсон үеийн алдагдлын хэмжээг тооцоололдоо Бэйзэлийн тоон нөлөөллийн судалгаа 3, Техник зааварчилгаа, дефолт болсон үеийн алдагдлын хэмжээний суурь аргыг ашигладаг.

Тайлант хугацааны турш тооцоолол хийх арга барил эсвэл чухад таамаглалуудад мэдэгдэхүйц хэмжээний өөрчлөлт ороогүй болно.

**Хөрвөх чадварын эрсдэл.** Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь ХДК нь мөнгө эсвэл өөр бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд үүсч болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. ХДК энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээж, ХДК-ийн нэр хүндийг сэвтээхгүйн тулд санхүүгийн өр төлбөрийн төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байхыг зорилго болгож ажилладаг.

ХДК нь мөнгөний хэрэгцээ шаардлагыг мөнгөн орлоготой тогтмол уялдуулан хянадаг ба мөнгөн гүйлгээний төсвийг тогтмол бэлдэж, үндсэн үйл ажиллагаа, санхүүжилт, мөн капитал зарцуулалтын хэрэгцээнд шаардлагатай мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг хангалттай түвшинд байлгадаг. Удирдлага ХДК-ийн хөрөнгийн томоохон хэсгийг богино хугацаат үнэт цаас зэрэг мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө бүрдүүлдэг бөгөөд бусад авлага нь (жишээ нь Эрх хүлээн авагч) Монголбанкинд төлөх адил хэмжээний өр төлбөртэй тэнцүү учир хөрвөх чадварын эрсдэлийг маш бага гэж үзэж байна.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдсэн хугацаагаар нь доорх хүснэгтэнд тодруулж байна. Энэхүү хүснэгтэнд толилуулагдсан дүн нь гэрээний үнийн дүнгийн дискаунтлаагүй мөнгөн гүйлгээний дүн болно. Хэрэв өр төлбөрийн дүн тогтмол биш тохиолдолд доор толилуулагдах дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж, тооцоолон гаргасан болно.

	1 сараас бага хугацаатай	3-12 сарын хугацаатай	12 сараас 5 жилийн хугацаатай	Нийт
<i>Мянган төгрөгөөр</i>				
Худалдааны болон бусад өр төлбөр	10,081	-	-	10,081
Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан	-	51,243,353	-	51,243,353
Монголбанкнаас авсан зээл	85,552,613	-	110,910,720	196,463,333
<b>Нийт</b>	<b>85,562,694</b>	<b>51,243,353</b>	<b>110,910,720</b>	<b>247,716,767</b>



**Хадгаламжийн Даатгалын Корпорац**  
**Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**18. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

2017 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн өр төлбөрүүдийг гэрээний үлдсэн хугацаагаар нь доорх хүснэгтэд харуулав.

	1 сараас бага хугацаатай	3-12 сарын хугацаатай	12 сараас 5 жилийн хугацаатай	Нийт
<i>Мянган төгрөгөөр</i>				
Худалдааны болон бусад өр төлбөр	10,583	-	-	10,583
Монголбанкнаас авсан зээл	-	-	190,808,477	190,808,477
<b>Нийт</b>	<b>10,583</b>		<b>190,808,477</b>	<b>190,819,060</b>

**Зах зээлийн эрсдэл.** Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд гадаад валютын ханшийн өөрчлөлт болон хүүгийн түвшний өөрчлөлт зэрэг ХДК-ийн орлого болон санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэ цэнэд нөлөөлөхүйц өөрчлөлтүүд орно. ХДК нь зах зээлийн эрсдэлийн удирдлагаар хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээнд эрсдэлийг барихын зэрэгцээ өгөөжийг оновчтой түвшинд байлгахыг зорилго болгон ажилладаг.

**Гадаад валютын эрсдэл.** ХДК-ийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох Төгрөгөөс бусад гадаад валютаар ажил гүйлгээ хийдэггүй. Иймээс гадаад валютын эрсдэл байхгүй.

**Хүүгийн эрсдэл.** ХДК нь санхүүгийн хэрэглүүрүүдийнхээ хүүгийн түвшнийг хянаж байдаг. Доорх хүснэгтэнд харгалзах тайлант хугацааны эцэс дэх үр ашигт хүүг тодруулж байна:

	2018 Төгрөг	2017 Төгрөг
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	0%-10.96%	0%-10.96%
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	12.88%-14.50%	9.63%-14.25%

ХДК-ийн хүү олдог хөрөнгүүд нь (мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө ба богино хугацаат хөрөнгө оруулалт) тогтмол хүүтэй. ХДК-ийн хүүтэй өр төлбөр 2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар хязгаарлагдмал хэмжээтэй буюу Монголбанкны жилийн 0.5 хувийн хүүтэй зээл болно. Иймд, удирдлага нь ХДК-ийн хүүгийн эрсдэлийг их биш бөгөөд хүүгийн түвшний өөрчлөлт нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй гэж үзсэн.

**Капиталын удирдлага.** ХДК нь Монголбанкны эсвэл ямар нэгэн хөндлөнгийн капиталын удирдлагын шаардлагуудаар зохицуулагддаггүй.

ХДК нь хөрөнгө оруулагчид, зээлдэгчид, олон нийт болон зах зээлийн итгэлийг өндөр байлгах үүднээс хангалттай хэмжээний капиталтай байхыг эрмэлздэг. ХДК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх эздийн өмч нь 318,742,131 мянган төгрөг (2017: 314,358,693 мянган төгрөг) байна.

**19. Санхүүгийн хэрэглүүрүүдийн хэмжилтийн ангиллаарх тодруулга**

СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр” нь санхүүгийн хөрөнгүүдийг хэмжилтээр нь дараах ангилалд хуваасан: а) Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ (“ААБҮЦ”) б) Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өрийн хэрэглүүр в) Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжигдэх өмчийн хэрэглүүр болон г) Хорогдуулсан өртөг (“ХӨ”). Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигддэг санхүүгийн хөрөнгүүдийг дотор нь (1) зайлшгүй тохиолдолд ангилсан (2) анхлан хүлээн зөвшөөрөхөд болон дараа үеийн хэмжилтээр ангилсан гэж 2 хуваана.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх энэхүү хэмжилтийн төрлөөрх санхүүгийн хөрөнгүүдийг доор харуулав:

**Хадгаламжийн Даатгалын Корпорац**  
**Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**19. Санхүүгийн хэрэглүүрүүдийн хэмжилтийн ангиллаарх тодруулга (Үргэлжлэл)**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Хорогдуулсан өртөг</b>	<b>Ашиг алдагдлаарх бодит үнэ</b>	<b>Нийт</b>
<b>Санхүүгийн хөрөнгүүд:</b>			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	397,409,518	-	<b>397,409,518</b>
Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	-	85,000,000	<b>85,000,000</b>
Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага	73,796,145	-	<b>73,796,145</b>
Даатгалын хураамжийн авлага	1,920,635	-	<b>1,920,635</b>
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	4,185,546	-	<b>4,185,546</b>
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>477,311,844</b>	<b>85,000,000</b>	<b>562,311,844</b>

2018 оны 12 сарын 31-ний байдлаар, ХДК-ийн бүх санхүүгийн өр төлбөрүүд хорогдуулсан өртгөөр хэмжигдэж байсан.

2017 оны 12 сарын 31-нээрх НББОУС 39 “Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт болон Хэмжилт” нь санхүүгийн хөрөнгүүдийг нь хэмжилтээр нь дараах ангилалд хувааж байсан: (а) Зээл ба авлага (б) Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт (в) Дуусах хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгүүд (г) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигддэг санхүүгийн хөрөнгүүд бөгөөд энэ нь дотроо (1) анхлан хүлээн зөвшөөрөлтөөр энэхүү ангилалд ангилсан (2) худалдах зорилгоор ангилсан хөрөнгүүд гэж ангилсна.

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх энэхүү хэмжилтийн төрлөөрх санхүүгийн хөрөнгүүдийг доор харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Зээл ба авлага</b>	<b>Борлуулахад бэлэн</b>	<b>Нийт</b>
<b>Санхүүгийн хөрөнгүүд:</b>			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	222,889,158	-	<b>222,889,158</b>
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт	-	85,000,000	<b>85,000,000</b>
Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага	84,599,061	-	<b>84,599,061</b>
Даатгалын хураамжийн авлага	1,940,923	-	<b>1,940,923</b>
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	109,270,112	-	<b>109,270,112</b>
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>418,699,254</b>	<b>85,000,000</b>	<b>503,699,254</b>

**20. Болзошгүй өр төлбөр ба үүрэг**

**Шүүхийн үйл явц.** ХДК-ийн бизнесийн хэвийн үйл явцад ХДК-ийн эсрэг зарга үүсгэгдэх боломжтой. ХДК-ийн өөрийн тооцоогоор заргаас үүдэн материаллаг гарз үүсэхгүй бөгөөд иймд санхүүгийн тайланд холбогдох нөөц байгуулаагүй болно.

2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар ХДК нь ямар нэг хуулийн заргад холбогдоогүй байсан болно.

**Татварын болзошгүй өр төлбөр.** ХДК нь ашгийн төлөө бус учир татвар төлдөггүй ба үүнтэй холбоотой болзошгүй өр төлбөр байхгүй.

**Үүрэг, барьцаа хөрөнгө ба бусад гэрээгээр хүлээх үүргүүд.** ХДК-д зээлтэй холбоотой ямар нэг үүрэг, барьцаанд тавигдсан болон хязгаарлагдсан хөрөнгө байхгүй бөгөөд 2018 оны 12 сарын 31 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн болон гүйцэтгэлийн баталгаа гаргаагүй. ХДК-д зээлийн гэрээтэй холбоотой гэрээгээр хүлээсэн санхүүгийн үүрэг байхгүй болно.

**21. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн тодруулга**

**Бодит үнэ цэнэ ба бодит үнэ цэнийн ангилал**

Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрт тодорхойлох ба эдгээр нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ)

болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход ихээхэн тохируулга хийгдэх өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Ашиглаж буй өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн тодорхойлолттой бүхлээр нь харьцуулан тооцдог.

ХДК-ийн голлох санхүүгийн хэрэглүүрүүд нь касс болон харилцах дансан дахь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, авлага болон бусад зээлээс (Монголбанкны зээл) бүрдэнэ.

**Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй боловч бодит үнэ цэнэ нь толилуулагдсан хөрөнгө ба өр төлбөр**

Төрийн банкинд оруулсан өмчийн хэрэглүүрээр хөрөнгө оруулалтаас бусад бүх хөрөнгө ба өр төлбөрүүд нь хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг (Тодруулга 10).

ХДК хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлдог:

(i) *Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд*

Хөрвөх чадвар сайтай, 1 жилээс доош богино хугацаат санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо байна.

(ii) *Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүд*

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалыг одоогийн ижил түвшний зээлийн эрсдэл, хугацаа бүхий хэрэглүүрийн хүүгийн түвшнээр дискаунт хийж тооцоолно. Иймд анх хүлээн зөвшөөрөгдөж буй зах зээлийн хүүгийн түвшин нь Монголын зах зээл дээр арилжаалагдаж буй ижил төрлийн санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн хүүтэй харьцуулагддаг. Хэрэв зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлт нь бага хэмжээтэй бол, санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо байна.

Удирдлага нь засгийн газрын үнэт цаасны (урт хугацаат үнэт цаасыг оролцуулан) хүүгийн түвшин өөрчлөгдсөн ч бодит үнэ цэнэ болон дансны үнийн хооронд материаллаг зөрүү үүсэхгүй гэдгийг хүүгийн түвшин, өөр өөр дуусах хугацаатай үнэт цааснууд, материаллаг байдал зэргийг харгалзан үзэж санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн зүгээс үнэлгээ хийсэн.

**Хадгаламжийн Даатгалын Корпораци  
Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**21. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн тодруулга (Үргэлжлэл)**

Бодит үнэ цэнийг түвшингээр нь бодит үнэ цэнийн шатлалд шинжилсэн бөгөөд бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгө өр төлбөрийн дансны үнэ дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	2018 оны 12 сарын 31			2017 оны 12 сарын 31				
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
<b>Санхүүгийн хөрөнгө</b>								
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	397,409,518	-	-	397,409,518	222,889,158	-	-	222,889,158
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	4,185,546	-	-	4,185,546	109,270,112	-	-	109,270,112
Эрх хүлээн авагч болон Засгийн газраас авах авлага	-	-	73,796,145	73,796,145	-	-	84,599,061	84,599,061
Даатгалын хураамжийн авлага	-	1,920,635	-	1,920,635	-	1,940,923	-	1,940,923
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	<b>401,595,064</b>	<b>1,920,635</b>	<b>73,796,145</b>	<b>477,311,844</b>	<b>332,159,270</b>	<b>1,940,923</b>	<b>84,599,061</b>	<b>418,699,254</b>
<b>Санхүүгийн өр төлбөр</b>								
Худалдааны болон бусад өглөг	10,081	-	-	10,081	10,583	-	-	10,583
Хадгаламж эзэмшигчдэд олгох нөхөн төлбөрийн нөөц сан	-	-	51,243,353	51,243,353	-	-	-	-
Монголбанкнаас авсан зээл	-	-	193,744,933	193,744,933	-	-	190,808,477	190,808,477
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	<b>10,081</b>	<b>-</b>	<b>244,988,286</b>	<b>244,998,367</b>	<b>10,583</b>	<b>-</b>	<b>190,808,477</b>	<b>190,819,060</b>

2018 болон 2017 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн хэрэгслийн 3-р түвшин дэх өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэд өөрчлөлт ороогүй болно.

**Хадгаламжийн Даатгалын Корпорац**  
**Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2018 оны 12 дугаар сарын 31**

**22. Холбоотой талуудын ажил гүйлгээ**

Холбоотой талууд ба тэдгээртэй хийсэн хэлцлүүд нь НББОУС 24 “Холбоотой Талын Тодруулга”-ийн дагуу үнэлэгддэг. Тодруулга 1-д дурьдсанчлан ХДК нь 100 хувь төрийн өмчит ашгийн бус байгууллага бөгөөд арилжааны банкуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. Иймд холбоотой талуудтай олон тооны нөлөө бүхий хэмжээний хэлцлийг хийдэг.

НББОУС 24-ийн дагуу ХДК-ийн бусад холбоотой талуудад Засгийн газрын шууд болон хамтарсан удирдлагад байдаг бусад төрийн өмчит компани, байгууллагууд багтдаг.

ХДК-ийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж Засгийн газрын буцалтгүй зээл зэрэг Засгийн газар болон бусад холбоотой талуудтай олон тооны нөлөө бүхий хэлцлийг хийдэг. ХДК-ийн ашигт ажиллагаа, өсөлтийн тогтвортой байдал нь Засгийн газрын дэмжлэгээс хамааралтай. ХДК-ийн үйл ажиллагааны орчны талаарх мэдээллийг Тодруулга 2-оос үзнэ үү.

Холбоотой талуудын ажил гүйлгээний дэлгэрэнгүйг доор толилуулав.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар холбоотой талуудын үлдэгдэл дүн:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Монголбанк</b>	<b>Сангийн яам</b>	<b>Төрийн банк</b>	<b>Бусад холбоотой тал</b>
Монголбанкнаас авсан зээл	(193,744,933)	-	-	-
Эрх хүлээн авагч, Засгийн газраас авах авлага	-	-	-	73,796,145
Өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	-	-	85,000,000	-
Өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалт	-	4,185,546	-	-
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	298,328,099	-	152,939	-

2018 онд холбоотой талуудтай хийсэн орлого зарлагын гүйлгээнүүд дараах байдалтай байна:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Монголбанк</b>	<b>Сангийн яам</b>
Хүүгийн орлого	26,039,440	3,552,196
Хүүгийн зардал	592,898	-

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар холбоотой талуудын үлдэгдэл дүн:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Монголбанк</b>	<b>Сангийн яам</b>	<b>Төрийн банк</b>	<b>Бусад холбоотой тал</b>
Монголбанкнаас авсан зээл	(190,808,477)	-	-	-
Эрх хүлээн авагч, Засгийн газраас авах авлага	-	-	-	84,599,061
Борлуулахад бэлэн үнэт цаас	-	-	85,000,000	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	-	109,270,112	-	-
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	197,241,713	-	25,647,445	-

2017 онд холбоотой талуудтай хийсэн орлого зарлагын гүйлгээнүүд дараах байдалтай байна:

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Монголбанк</b>	<b>Сангийн яам</b>
Хүүгийн орлого	14,397,811	24,277,511
Хүүгийн зардал	555,746	-

2018 онд гол удирдах ажилтнуудын цалин болон шагнал урамшуулал нийт 321,146 мянган төгрөг байсан ба үүний 48,000 мянган төгрөг нь шагналт цалин байсан (2017 онд 224,051 мянган төгрөг байсан ба үүний 48,000 мянган төгрөг нь шагналт цалин байсан).

### **23. Тайлант хугацааны дараах үйл явдлууд**

2019 оны 4 сарын 8-нд Монголбанк нь Төв банкны тухай хуулийн 19.1 болон 28.1.2 –р заалтууд болон Банкны тухай хуулийн 68.1 дэх заалтыг үндэслэн Капитал Банк ХХК-г албадан татан буулгах тухай #А-96 тоот тушаалыг батласан. Энэхүү тушаал дээр үндэслэн 2019 оны 4 сарын 8-нд Хадгаламжийн Даатгалын Корпораци нь Мөнгөн Хадгаламжийн Даатгалын Тухай хуулийн 15.1-р заалтын дагуу Капитал банкны хадгаламж эзэмшигчдэд нөхөн олговор олгох тухай #72 тоот тушаалыг батласан.

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсноос хойш буюу 2019 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.

### **24. 2018 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлогууд**

2017 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд хүчин төгөлдөр байсан нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь СТОУС 9-тэй холбоотой доор байдлаар өөрчлөгдсөн:

**Санхүүгийн хэрэгсэл – гол хэмжилтийн нэр томь о.** Санхүүгийн хэрэгслийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ, өртөг эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгадаг.

Өртөг нь хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эсвэл бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх нөхөн төлбөрийн дүн бөгөөд үүнд *гүйлгээний зардлууд* багтдаг. Зах зээл дээр санал болгож буй тодорхой жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь тодорхойлох боломжгүй өмчийн хэрэгслүүдэд оруулсан хөрөнгө оруулалтыг зөвхөн өртгөөр хэмжиж болно. Холбогдох деривативууд нь тэрхүү хөрөнгийн бирж дээр ангилагдаагүй өмчийн хэрэгслүүдийг хүргэх үед төлбөр нь төлөгдсөн байх ёстой байдаг.

**Санхүүгийн хэрэгслийн ангилал:** Санхүүгийн хөрөнгүүдийг хэмжилтийн зорилгоор дараах ангилалд хуваадаг: (а) зээл болон авлага, (б) борлуулах зорилготой санхүүгийн хөрөнгө, (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө, болон (г) бодит үнэ цэнээр бүртгэгдэх, орлого зарлагад нөлөөлөх санхүүгийн хөрөнгө (“БҮЦБОЗНСХ”). Бодит үнэ цэнээр бүртгэгдэх, орлого зарлагад нөлөөлөх санхүүгийн хөрөнгө нь дараах дэд хэсгүүдээс бүрдэнэ: (1) анхлан хүлээн зөвшөөрөгдөхдөө энэ хэсэгт ангилагдсан хөрөнгө, (2) арилжааны зориулалттай эзэмшдэг гэж ангилагдсан хөрөнгө.

Зээл болон авлагууд нь тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, ХДК-ийн эзэмшиж буй ойрын хугацаанд зарж борлуулах төлөвлөгөөгүй дериватив бус санхүүгийн хөрөнгүүд юм. ХДК-ийн зээл болон авлагууд нь санхүүгийн байдлын тайлан дахь “Эрх хүлээн авагчаас авах авлага”, “Шимтгэлийн хураамжийн авлаг”, “Засгийн газрын үнэт цаас ” мөн “мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгүүд” –ээс бүрдэнэ.

**Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт.** Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш дор дурдсан нэг буюу олон үйл явдлаас (“гарз учруулсан үйл явдлууд”) шалтгаалан санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгүүдийн ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ нь өөрчлөгдсөнийг үнэн зөв тооцох боломжтой болсон тохиолдолд л тайлант жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрдөг. Хэрэв ХДК нь дан ганцаар үнэлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнэ буурсаныг илэрхийлэх бодит нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол тухайн санхүүгийн хөрөнгийг ижил төрлийн зээлийн эрсдэлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт багтаан уг бүлгийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлдэг.

ХДК-ийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохдоо авч үздэг үндсэн хүчин зүйлс нь тэдгээрийн хугацаа хэтрэлтийн байдал, мөн аливаа холбогдох барьцаа хөрөнгийг борлуулах бололцоо юм. Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн эсэхийг илэрхийлэх бодит нотолгоо тодорхойлоход дараах бусад үндсэн шалгууруудыг мөн авч үздэг:

- хуваарьт төлбөрүүдийн аль нэг нь хугацаа хэтэрсэн бөгөөд хугацаа хэтрэлт нь төлбөр тооцооны системээс үүссэн сааталтай хамааралгүй;
- харилцагч тал санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон нь ХДК-ийн олж авсан санхүүгийн мэдээллээр баталгаажсан;

**24. 2018 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)**

- харилцагч тал дампуурлаа зарлах буюу санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байгаа;
- улсын буюу орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал харилцагч талд нөлөөлөхүйцээр өөрчлөгдсөнөөс түүний төлбөр төлөлтийн байдал муудсан; эсвэл
- зах зээлийн нөхцөл байдал муудсанаас барьцаа хөрөнгийн үнэ цэнэ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан.

ХДК нь харьцангуй цөөхөн зээлдэгчид (харилцагчид болон бусад зээлдэгчид)-тэй тул хорогдуулсан өртгөөр бүртгэдэг бүх санхүүгийн хөрөнгүүддээ тусгай үнэлгээ хийдэг, өөрөөр хэлбэл тус бүрд нь үнэ цэнийн бууралтын бодитой нотолгоо байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв нэг бүрчлэн үнэлгээ хийсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөх бодитой нотолгоо байхгүй гэж үзвэл тус хөрөнгийг хамтарсан үнэлгээнд хамруулна. 2017 оны 12 сарын 31-ний байдлаар, хамтарсан үнэлгээн дээр суурилсан үнэ цэнийн бууралтын сан шаардлагагүй гэж үзсэн. Хэрэв харилцагч талын санхүүгийн хүндрэлийн улмаас

Хэрэв хорогдуулсан өртгөөр бүртгэгдэж байсан санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ нь харилцагч талын санхүүгийн хүндрэлээс болоод дахин хэлэлцэж, өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтыг өөрчлөлт хийхээс өмнөх буюу анхны үр ашигт хүүгийн түвшингээр хэмжинэ. Хэрэв хөрөнгийн эрсдэл ба өгөөж бүрэн өөрчлөгдсөн бол дахин хэлэлцэгдсэн тус хөрөнгийг данснаас бүр мөсөн хасч шинэ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Энэ нь ерөнхийдөө анхны мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ болон хүлээгдэж буй шинэ мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүүтэй байдлаар нотлогддог.

Үнэ цэнийн бууралтыг нөөцийн сангийн дансанд бүртгэж хөрөнгийн дансны үнийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын (зээлийн хэрэгжээгүй ирээдүйн алдагдлыг оруулаагүй дүнгээр) анхны үр ашигт хүүгээр тооцсон өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэнэ.

Хэрэв үнэ цэнийн бууралт дараагийн тайлант хугацаанд багассан бөгөөд уг бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдалтай холбох боломжтой бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг үнэ цэнэ бууралтын сангийн дансанд залруулга хийх замаар тухайн жилийн орлого, зарлагад бүртгэнэ.

Эргэн төлөгдөх боломжгүй болсон хөрөнгийн дүнг хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авсан бөгөөд гарзын хэмжээ тодорхой болсон үед холбогдох үнэ цэнийн бууралтын гарзад байгуулсан нөөцийн эсрэг хаана. Өмнө нь хасагдуулсан хөрөнгийн дүн дараа нь нөхөн төлөгдсөн тохиолдолд нөхөн төлөгдсөн дүнг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэж үнэ цэнийн бууралтын гарз дансыг бууруулна.

**Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт.** Энэнхүү ангилалд ХДК буй төлбөр түргэн гүйцэтгэх зорилгоор эсвэл хүү, валютын ханш эсвэл хувьцааны үнэ өөрчлөгдсөн тохиолдолд зарж борлуулж болдог хөрөнгө оруулалтын үнэт цааснууд багтдаг.

Хөрөнгө оруулалтын үнэ цааснууд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг. Хэрэв тухайн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг найдвартай тооцох боломжгүй бол тэдгээрийг өртгөөр нь бүртгэж үнэ цэнийн бууралтыг тогтмол тооцно. Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг анхлан бүртгэснээс хойш нэг болон хэд хэдэн үйл явдлын улмаас (“алдаглын үйл явдал”) үнэ цэнэ буурсан бол цэнийн бууралтын алдагдлыг тухайн жилийн ашиг алдагдалд бүртгэнэ.

Борлуулахад бэлэн өмчийн хэрэглүүрийн ногдол ашгийг төлбөр хүлээн авах эрх ХДК-д үүсч, ногдол ашиг авах нь тодорхой болсон үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бусад хэсгийг тухайн хөрөнгө оруулалт эргүүлэн хүлээн зөвшөөрөгдөх эсвэл үнэ цэнийн бууралтад орох хүртэл бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба энэ үед нийт олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогоос тайлант жилийн ашиг, алдагдалд шилжин ангилагдана. Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг болон хэд хэдэн үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд алдагдал үүсэх үед үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өмчийн хэрэглүүрт үнэт цаасны бодит үнэ нь өртгөөсөө бага төвшинд үргэлжлэн буурах нь тухайн үнэт цаас үнэ цэнийн бууралтад орсны илэрхийлэл юм. Худалдаж авахад гарсан зардал болон одоогийн бодит үнийн зөрүүгээс ашиг, алдагдалд өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассанаар тооцоологддог үнэ цэнийн бууралтын нийт алдагдал



**24. 2018 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (Үргэлжлэл)**

нь бусад дэлгэрэнгүй орлогоос тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө. Өмчийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахгүй ба цаашид гарсан аливаа олзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Хэрэв дараа дараагийн хугацаан дахь борлуулахад бэлэн ангилалд багтсан өрийн хэрэглүүрийн бодит үнэ өсч, энэхүү өсөлт нь ашиг, алдагдалд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрснөөс хойших үйл явдалтай холбоотой бол жилийн ашиг алдагдлаас үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

**Орлого хүлээн зөвшөөрөлт.** Орлогын дүнг хүлээн авсан эсвэл авахаар болсон зүйлийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Бараа солилцоогоор авсан бараа бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй бол солилцоонд өгсөн бараа эсвэл үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжинэ. ХДК нь орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой, аж ахуйн нэгж нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж хүртэх боломжтой, ХДК-ийн үйл ажиллагаа тус бүрийн хувьд дор дурдсаны дагуу тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Бараа солилцоогоор авсан бараа бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй бол солилцоонд өгсөн бараа эсвэл үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжинэ.

**Бараа бүтээгдэхүүний орлого.** Бараа бүтээгдэхүүн борлуулснаас олсон орлогыг тухайн барааны эрсдэл болон өгөөж шилжсэн цагт буюу ихэвчлэн бараа бүтээгдэхүүний ачуулсан үед бүртгэдэг. Хэрэв Групп нь бараа бүтээгдэхүүнийг тодорхой байршилд хүргүүлэхийг хүлээн зөвшөөрсөн бол, бараа хүргэлтийн цэг дээр үйлчлүүлэгчид хүргэх үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

**Үйлчилгээний орлого.** Үйлчилгээний орлогыг үйлчилгээ үзүүлсэн үед, нийт үзүүлэх ёстой үйлчилгээнд үзүүлсэн үйлчилгээний эзлэх хувиар буюу тухайн гэрээний гүйцэтгэлийн хувиар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.